

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН**  
**2009 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН**  
**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2010.03.16.

Алтай хот

**НЭГ. БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:**

**1.1. Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт.**

УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2007-2021 он)”-д тулгуурлан Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлого (2008-2021 он)-ыг боловсруулсан.

Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлого (2008-2021 он)-д Үндэсний хөгжлийн цогц бодлого (2007-2021 он)-ын зэрэгцээ “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги (2010 он хүртэл)”, “Монгол Улсын Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр (2015 он хүртэл)” болон Монгол Улсын хөгжлийн бодлогын бусад баримт бичгүүдийн үзэл санаа тусгалаа олсон болно.

Мөн “Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлого (2009-2021 он)”-д “Аймгийг хөгжүүлэх төсөл”, “Говь-Алтай аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр”, “Говь-Алтай аймагт барилгын салбарыг 2020 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө”, “Говь-Алтай аймгийн мэдээлэл, холбооны салбарыг хөгжүүлэх хөтөлбөр /2008-2015 он/”, “Говь-Алтай аймагт байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар 2010 он хүртэл хэрэгжүүлэх мастер төлөвлөгөө”, “Аймгийн Мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр /2005-2015 он/”, “Ногоон хувьсгал дэд хөтөлбөр”, “Газар тариаланг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр /2008-2012 он/”, “Атрын гурав дахь аян (Газар тариалангийн хөгжлийн дэд хөтөлбөр) /2008-2010 он/”, “Аймгийн боловсролын салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө /2008-2015 он/”, “Говь-Алтай аймгийн онцлогт нийцсэн Мянганы хөгжлийн зорилтууд /2008-2015 он/” зэрэг аймгийн хэмжээний хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн үзэл санаа, хэрэгжилтийн явц, үр дүн, залгамж чанар тусгагдсан болно.

Сангийн яам, Говь-Алтай аймаг, НҮБХХ-ын хооронд Мянганы Хөгжлийн Зорилтуудыг хэрэгжүүлэхээр харилцан ойлголцлын санамж бичгийг 2007 оны 12 сард баталснаар 2008-2009 онуудад орон нутгийн МХЗ-ыг хэрэгжүүлэх төслийн нэгж ажиллаж, Говь-Алтай аймгийн МХЗ-ын хэрэгжилтийн анхны тайлан илтгэл, МХЗ-ыг хэрэгжүүлэх хэрэгцээний үнэлгээний тайланг боловсруулан гаргаж, иргэд олон нийтэд суртчилсан байна. Мөн аймгийн Мянганы хөгжлийн зорилтууд, түүний шалгуур үзүүлэлтүүд, 2015 оны хүрэх түвшинг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлууллаа.

**Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлогын тухай**

**Говь-Алтай аймгийн хөгжлийн 2021 он хүртэлх алсын харааг** хүний хөгжилд тулгуурлан эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж, хүн амын амьдралын түвшинг тууштай дээшлүүлэн, Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, Монгол Улсын өөрөө өөрийгөө тэтгэдэг, оновчтой бүтэцтэй, мэдлэгт суурилсан эдийн засагтай, цэцэглэн хөгжиж буй аймаг болоход оршино гэж тодорхойлсон.

**Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлогыг дараах таван тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр тусгав. Үүнд:**

- 1) Аймагт мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлнэ.
- 2) Дэлхийн болон дотоодын зах зээлд өрсөлдөх чадвартай, хувийн хэвшилд тулгуурласан экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж, аймгийн эдийн засгийг олон талтай, мэдлэгт суурилсан болгоно.
- 3) Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж хөгжлийн таатай орчин бүрдүүлнэ.
- 4) Аймгийн төв, сумдын төвүүдийг хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана.
- 5) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон чадавхийг бий болгон цөлжилтийг сааруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах эдгээр болно.

Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлогод нийгэм, эдийн засаг, байгаль орчны хүрээний урт хугацааны стратегийн зорилтууд, хүрэх үр дүнг 2008-2015 он, 2016-2021 он гэсэн үндсэн хоёр үе шатаар тусгасан.

**Говь-Алтай аймгийн хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийн талаар товч мэдээллэвэл:**

Эрүүл мэндийн салбарт эмнэлгийн байнгын хяналтанд 1 хүртэлх насны 1229 хүүхэд, 3484 жирэмсэн болон төрсөн эх байгаагаас гадна эрүүлжүүлэн эмчлэх хяналтын заалтаар 10555 хүн хяналтанд хамрагдаж байна. Эдгээр хяналтанд хамрагдаж байгаа хүмүүс нь хүн амын 27,5 хувийг эзлэж байна. “Эхийн эрүүл мэндийг дэмжих сан” бий болгож, эмзэг бүлгийн өрхийн нөхөн үржихүүн насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Тус сангаас жирэмсэн болон төрсөн эх, хүүхдийг хүргэж өгөх унааны зардалд 232.0 мянга, А хүрээний H1N1 вирусын халдвараас сэргийлэх, дархлаа сайжруулах амин дэмийн зардалд 9718.0 мянган төгрөгийг тус тус зарцуулаад байна.

Боловсролын салбарт 2009-2010 оны хичээлийн жилд 28 сургуулийн 467 бүлэгт 12686 хүүхэд суралцаж байна. Дарив, Чандмань, Дэлгэр сумдын сургуулийг 12 жилийн бүрэн дунд сургууль болгон хэв шинжийг нь өөрчилж 10-р ангийн элсэлт аван хичээллэж байна. 2009-2010 оны хичээлийн жил сургуулийн өмнөх боловсролын 27 цэцэрлэгийн 117 бүлэгт 3683 хүүхэд хамрагдаж байгаагаас цэцэрлэгт 2429, хувилбарт сургалтаар 1254 хүүхэд хүмүүжиж байна. Аймгийн хэмжээнд 650 үндсэн багш ажиллаж байгаагийн 263 нь бага ангийн багш юм. Багшийн хангалт 98.5 хувьтай байна.

Ажилд зуучлах, ажил мэргэжилгүй иргэдийг мэргэжлийн сургалтанд үнэгүй хамруулах, хувиараа болон өрхийн аж ахуй эрхлэхийг хүссэн иргэдэд жижиг зээл олгох, мөн нийтийг хамарсан ажилд эмзэг бүлгийн иргэдийг өргөнөөр хамруулж түр болон байнгын ажлын байраар хангах зэргээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд шинээр 2160 хүн ажлын байртай болж, орлого нь нэмэгдлээ. Бүртгэлтэй 1029 ажилгүйчүүд байгаа ба ажилгүйдлийн түвшин 3.8 болж өмнөх оноос 0.1 пунктээр буурсан байна. Иргэдийн эрүүл мэндийн даатгалд 45900 хүн хамрагдсанаас 9178 нь малчин байна.

2009 онд НХХЯ-аас аймаг бүрийн ядуурлаас гаргах өрхийн тоог тодорхойлсноор Говь-Алтай аймагт 294 өрх хуваарилагдсан бөгөөд бүх өрх “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө” боловсруулсан. Дээрх ажлын хүрээнд Нийтийг хамарсан ажилд 19 сумын 85 өрхийн 145 хүнийг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлд 4 сумын 8 өрхийг, Мэргэжил олгох сургалтанд 33 өрхийн 33 хүнийг хамруулж тус өрхүүдийн орлого нь тодорхой хэмжээгээр дээшилж байна.

Орон нутгийн төсвийн орлогын биелэлт 102.2 хувь Зарлагад эзлэх орлогын хувь 68.2-д хүрч зорилтот түвшингээс 8.1 функтээр давсан байна.

2009 оны мал тооллогын дүнгээр 2 сая 171.8 мянган толгой мал тоолуулсан байна. Тайлант онд аймгийн хэмжээнд үр тариа 1293.3 тн, төмс 1807.3 тн, хүнсний ногоо 833.5 тн, жимс жимсгэнэ 71 тн, тэжээлийн ургамал 1464.9 тн, эмийн ургамал 2 тн- ыг тус тус хураан авлаа

Цээл сумын Таяннуурын төмрийн хүдрийн ордод үйл ажиллагаа явуулж буй “Алтайн хүдэр” ХХК нь тайлант онд эхний экспортоо хийсэн бөгөөд хүдрийн баяжмалын агуулгаа нэмэгдүүлэх зорилгоор 6-р сард нэмж, 1 соронзон сеператорыг суурилууллаа.”Алтайн хүдэр” ХХК 2009 оны 4 дүгээр сард 14000 орчим тонн, 10-р сард 27950 тн нийт 41950 орчим тонн хүдрийг экспортонд гаргаад байна. Тайлант онд Мааньтын нүүрсний уурхайгаас 15000 орчим тонн, Зээгтийн нүүрсний уурхайгаас 3280 тонн нийтдээ 18280 тонн нүүрс олборлоод байна.

## **1.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт**

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хяналтанд авсан 79 заалтын эхний жилийн биелэлт нь 29.4 хувьтй байна. Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс орон нутагтай холбоотой заалтуудыг сонгон хяналтанд авсан бөгөөд хэрэгжилтийг хувиар авч үзвэл: 70 хувьтай 2, 50 хувьтай 14, 30 хувьтай 47, хөрөнгийн эх үүсвэр дутагдалтай, болон хэрэгжих хугацаа болоогүй 8 заалт байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтоо тайлант онд үндсэнд нь хэрэгжүүлж ажиллалаа. Эрүүл мэндийн салбарт сумын эмнэлгүүдийн стандартыг хангуулахад онцгой анхаарч ажилласнаар 7 сумд худаг гаргаж, 2 сумын эмнэлгийг инженерийн шугам сүлжээнд холбосон нь бодит ажил боллоо.

Боловсролын салбарт Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад Үдийн хоол олгохоос бусад асуудлууд үндсэндээ биелэгдлээ.

Нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлд ахиц дэвшил гарч, сумын төвүүдийн нийгмийн халамжийн бүх сангуудыг нэгсэн программ, сүлжээнд холбож тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээг хөнгөн шуурхай давхардалгүй олгож байна.

Ахмад настны эрүүл мэндийг сайжруулах зорилгоор “Blue sky” ТББ-тай хамтран физик эмчилгээ, бариа засал хийдэг болж, ахмадын сувилалд 19 сумын 188 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг амрааж сувиллаа. Мөн “Тогтвортой амьжиргаа II” төслийн 8.9 сая төгрөгийн санхүүжилтээр ахмадын сувилалд тохижууллаа.

Хүн амын хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн мах, сүү, гурил, төмс гэрэг гол нэрийн хүнсний ногоогоор хангахад анхаарлаа чиглүүлж “Тулга-Алтай” ХХК үйлдвэрлэлийн аргаар 220 л сүү, 3 тонн тараг, ааруул үйлдвэрлэлээ. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд Есөнбулаг, Хөхморьт сумдад бага оврын сүүний үйлдвэр байгуулахад нь зээл олгоод байна.

2009 онд аймгийн хүн амын гурлын хэрэгцээний 12 хувь, төмсний 53 хувь, хүнсний ногооны 36 хувь, сүүний 40 хувийг тус тус хангасан нь өмнөх жилээс өссөн дүнтэй байна.

Байгаль орчны тэнцвэрт харьцааг хангах зорилтын хүрээнд цөлжилтийг багасгах зорилгоор Бигэр сумд 3000 м<sup>3</sup> ус хуримтлуулах хөв байгуулж, 15 булаг шандын эхийг хашиж хамгааллаа.

Аймгийн төвийн гүний худгын усны түвшин буурсанаар хүйтний улиралд цэвэр усны болон дулааны усан хангамжид доголдол гарч холбогдох мэргэжлийн байгууллагуудад энэ асуудлыг шийдвэрлүүлэх талаар асуудлыг тавьж ажилллаа.

### Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт

Засгийн газрын тогтоолоор батлагдсан үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалт болон үр дүн биелэлтэнд нь хяналт тавьж, явц, дүнд хяналт шинжилгээ хийж, хэрэгжилтийн үр дүн мэдээг тогтоосон хугацаанд нь Засгийн газрын 2006 оны 160, 2009 оны 285-р тогтоолуудын дагуу холбогдох газарт хүргүүлж ажиллалаа.

Засгийн газраас аймагтай холбогдох салбарын чиглэлээр шинээр боловсруулж хэрэгжүүлэх болон хэрэгжиж байгаа Үндэсний хөтөлбөрийн сэдэвчилсэн жагсаалтыг үндэслэн аймаг биелэлтийг нь тооцдог хөтөлбөрүүдтэй харьцуулж, биелэлтийг нь тооцлоо.

Орон нутагт хэрэгжүүлэх заалттай 69 хөтөлбөрт улсын төсвөөс 1524.6 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 2187.2 мянган төгрөгийг 3 хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд зарцуулсан байна.

Ихэнх хөтөлбөрүүд орон нутгийн төсвөөс санхүүжих заалттай гардаг бөгөөд орон нутгийн төсвийн хүндрэлтэй байдлаас шалтгаалж зарим хөтөлбөр биелэгдэх боломжгүй байна. 2009 онд орон нутгийн төсвөөс Агаарыг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор цаг уур агаарын чанарын бохирдлыг тодорхойлох багаж суурилуулж, байр барихад 1050.0 мянган төгрөг, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Аймгийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулахад зориулж 408.0 мянган төгрөг, Нэг цэгийн үйлчилгээ байгуулах дунд хугацааны хөтөлбөр хэрэгжүүлж, байр тохижуулах, танилцуулах самбар хийхэд 729.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Орон нутгийн төсвөөс гадна үндэсний хөтөлбөрүүдийг сурталчилж ажилласнаар хувийн хөрөнгө оруулалт, иргэдийн санал санаачилгууд ч нилээдгүй гарч байна. Жишээ нь: Ойн тухай үндэсний хөтөлбөрийн хүрээнд Дарив сумын 2-р багийн малчин О.Даш Харгана түрүүний услалтын системийг түшиглэн өөрийн санаачилгаараа 125 ширхэг хайлаас, бургас, чацарганы суулгацыг тарьж ургуулсан байна.

Түүнчлэн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээнд иргэдийн санал санаачилгаас гадна Төрийн бус байгууллагууд, гадна дотны төслийн нэгжүүд ч оролцдог боллоо. Нэг суурин нэг бүтээгдэхүүн хөтөлбөрийн хүрээнд гэхэд Ховд аймагт зохион байгуулагдсан “Баруун бүсийн Түншлэл” үзэсгэлэн худалдаанд 28 аж ахуй нэгжийн төлөөлөл, 21 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 15,8 сая төгрөгийн борлуулалт хийлээ. Аймгийн бренд бүтээгдэхүүнийг олшруулах, үйлдвэрлэл борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор “Алтайн Түншлэл” үзэсгэлэн худалдааг 2009 оны 09 сарын 11-12-ны өдрүүдэд Говь-Алтай Аймгийн Засаг Даргын Тамгын Газар, Худалдаа аж үйлдвэрийн танхим, Мерси Корын Төлөөлөгчийн газар, Аймгийн Хүнс Хөдөө Аж Ахуй Жижиг Дунд Үйлдвэрийн газар, Есөнбулаг сумын Засаг Даргын Тамгын Газар, Стандартчилал Хэмжилзүйн Хэлтэс, Мэргэжлийн Хяналтын Газар, Алтай Швейцарь сан, Жижиг Дунд Үйлдвэрийг Дэмжих Инкубатор төв хамтран “Алтай түншлэл-2009” үзэсгэлэн худалдааг 6 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. “Алтайн Түншлэл-2009” үзэсгэлэн худалдаанд Говь-Алтай, Ховд, Баянхонгор аймаг, Улаанбаатар хотын нийт 139 бизнес эрхлэгч, малчид, тариаланчид 20 нэр төрлийн 139,9 сая төгрөгийн бүтээгдэхүүнээр оролцож 80,5 сая төгрөгийн борлуулалт хийгдлээ.

Улсын төсвөөс санхүүжиж амжилттай сайн хэрэгжсэн хөтөлбөрүүдээс дурьдахад:

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрөөр ХХААХҮЯ-наас 570 сая, орон нутгаас 90 сая, МШБнаас 180 сая бүгд 840 сая төгрөгийг байршуулсан ба 94 иргэн аж ахуйн нэгжид 840.0 сая

төгрөгийн зээлийг олгоод байна. Үйлдвэржүүлэлтийн жилийн ажлын хүрээнд жилийн ажлыг зохион байгуулах хороог 18 хүний бүрэлдэхүүнтэйгээр аймгийн Засаг даргын захирамжаар байгууллаа. Өрхийн үйлдвэрлэлийн хөтөлбөр, Жижиг дунд үйлдвэрлэлийн дэд хөтөлбөрийг тус тус боловсруулж жилийн ажлын төлөвлөгөөг 3 бүлэг 54 заалттайгаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллаа. Жилийн ажлын хэрэгжилтийн явцыг 9-р сард аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулсны дээр Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэлжүүлэх ажлын бэлтгэлийг хангах цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхой болгож, 300 гаруй иргэдийг хамруулсан судалгааг явуулж үйлдвэрлэлийн хүчин чадал, хөрөнгө оруулалт, ажиллагсадын тоо, шаардлагатай сургалтын хэрэгцээ, төхөөрөмжийн гарал үүсэл, лизингийн үйлчилгээнд хамрагдах эсэх болон бусад асуудлуудаар судалгаа хийж нэгтгэлээ.

Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2009 онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 16 нэр төрлийн вакцин татан авч, 41 аж ахуй нэгжид захиалгын дагуу хувиарлан олгож 2122,8 мянган толгой малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан. Мөн паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 2234.0 мал хамрагдахаас 2266.6 мянган толгой мал хамрагдсан. 2000 адуунд ям, 1000 үхэрт сүрьеэ өвчний харшил сорилын шинжилгээ хийхээс Жаргалан, Дарив сумын 2000 адуунд ям өвчний 1000 үхэрт сүрьеэ өвчний харшил сорилын шинжилгээг тус тус хийсэн. Бруцеллёз өвчний шинжилгээ 13641 хээлтүүлэгч малд хийж, 2095 дээжинд ХХСН өвчний, 4 тархинд галзуу өвчний, 28 дээжинд бусад бактериологийн, 3069 дээжинд сүүний цагирган урвалын, 6 дээжинд паразитлогийн, 413.6 тн маханд, 55.3 тн сүүнд, 32057 ширхэг арьс ширэнд, 1971 ширхэг годонд тус тус МЭАЦ-ийн шинжилгээ хийсний дүнд малын халдварт өвчний тоо эрс буурлаа.

Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор 2009 онд эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр загвар мал аж ахуйг бий болгож, Есөнбулаг сумд цөм сүргийн мал аж ахуйд 125 тулман хөхт ямааг Бугат, Төгрөг, Тонхил, Дарив сумаас шилж сонгон авч, 1000 өндөглөгчийн дулаан байр барьсан ба иргэн С.Бөхбаатар тахианы мал аж ахуйгаа өргөтгөж, ЖДҮХ сангаас 7.6 сая төгрөгийн зээлээр тахиагаа авч ажилаа эхлээд байна.

“Ус харуул-Алтай” ХХК, ЖДҮХ сангаас 50.0 сая төгрөгийн зээл авснаар сүүний үхрээ төвийн бүсээс авч, үхрийн дулаан байр, худаг, сүү боловсруулах цехүүдийн байрыг ашиглалтанд оруулсан ба 250 га бэлчээрийг хашиж хамгаалах тор, шонг бэлтгэснээр сүүний үнээний фермер шинээр байгуулан ажиллуулж байна. “Хонгор булаг” ХХК саалийн 10 үнээний, Дэлгэр сумын “Сор-Манлай” нөхөрлөл сүүний үнээний Фермер байгуулах зээлүүдийг ЖДҮХ сангаас авч бэлтгэлээ хангалаа. 2009 онд Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих зорилгоор ЖДҮХ сангаас мал аж ахуйн нэгж, иргэдэд нийтдээ 190.4 сая төгрөгийн зээлийг журмын дагуу олгууллаа.

Малын чанар сайжруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд Бог малын ангилалт аттестатчилалыг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон МУА-ны шинжээч мэргэжилтнүүд бүхий ажлын хэсэг цөм сүргийн 5 сумд 100.2 мянган эм хонь, ямаа 2.4 мянган хээлтүүлэгч малд ангилалт, аттестатчилалыг чанартай явуулж 2.6 мянган толгой цөм сүрэг бүрдүүлж анги, чанарыг тогтоов.

Дэлгэр, Тайшир, Есөнбулаг, Шарга сумдын хонин сүргийн махан ашиг шимийг сайжруулах үржлийн ажлын төлөвлөгөөтэй ажиллаж Америкийн махны Соффолк, Дорсель үүлдрийн болон Торгууд, Барга, Үзэмчингийн эрлийз хээлтүүлэгч бойжуулан үржилд ашиглан эдгээр сумдын хонин

сургийн 14-27 хувьд селекц явуулж, намрын жингээр 2-6 кг-аар амьдын жин нэмэгдсэн үр дүнд хүрч байна.

"Ногоон хувьсгал" Засгийн газрын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, үр дүнг дээшлүүлэх арга хэмжээ авч ажилласнаар 2009 онд "Ногоон хувьсгал" хөтөлбөрт 18 аж ахуйн нэгж, 240 өрх хамрагдаж үр тариа 190 га-д, төмс 120 га-д, хүнсний ногоо 54.9 га-д, тэжээлийн ургамал 294.8 га-д, жимс жимсгэнэ 16 га-д тус тус тарьж үр тариа 270.4 тн, төмс 715.8 тн, хүнсний ногоо 290.8 тн, тэжээлийн ургамал 560.1 тн, жимс жимсгэнэ 37 тонныг тус тус хурааж авлаа.

Тус хөтөлбөрийн хүрээнд сумууд 31 удаа сургалт зохион байгуулж 435 иргэн хамрагдсан байна. Мөн 3330 м2 талбай бүхий 48 хүлэмжийг ашиглаж, 34.5 тн нарийн ногооны ургац хураан авч амьжиргаагаа дээшлүүлсэн байна.

Хаврын тариалалтын үеэр "Ногоон хувьсгал" төв штабаас 8.9 сая төгрөгийн, аймгийн салбар штабаас 2 сая төгрөгийн хүнсний ногооны үрийг газар тариалан голлон эрхэлдэг Халиун, Шарга, Чандмана, Бигэр, Гуулин, Баянтоорой, Есөнбулаг, Бугат, Тайшир, Төгрөг сумдын 42 тариаланч иргэд, аж ахуйн нэгжүүдэд нийлүүлсэн нь үрээр хангах ажилд ихээхэн дэмжлэг болсон.

Биологийн төрөл зүйлийг хамгаалах хөтөлбөрийн хүрээнд Дэлхийн банк, ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Алтай-Соёны биологийн төрөл зүйлийг хамгаалах төслийн санхүүжилтээр ШУА-ийн биологийн хүрээлэн болон мэргэжлийн байгууллагууд хамтран Монгол орны уулын туруутны популяцийн нөөцийн үнэлгээний ажлыг амжилттай хиилээ.

Дээрх амжилттай хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдээс гадна Үдийн хоол" хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам батлагдаагүйгээс, Озоны үе давхаргыг хамгаалах, Чанарын болон байгаль орчны удирдлагыг дэмжих, Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай зэрэг хөтөлбөрүүд тайлант онд хөрөнгийн эх үүсвэргүйгээс хэрэгжсэнгүй.

## **ХОЁР: БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ҮР ДҮН:**

### **2.1. Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт**

Улсын эдийн Засаг нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн аймагтай холбоотой 12 заалтын биелэлт нь 100 хувьтай 7, 90 хувьтай 4, 50 хувийн биелэлттэй 1 заалт байна. Монгол улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн товч мэдээлэл:

Аймгийн Засаг даргын 2009 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 150 дугаар захирамжаар Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор арилжааны банкаар дамжуулан зээл олгох төслийг сонгон шалгаруулах дэд комиссыг томилсон.

Төсөл сонгон шалгаруулах дэд комисс ЖДҮ-ийг дэмжих сангаас зээл авч үйлдвэрээ өргөтгөх, шинэ чиглэлээр үйлдвэрлэл үйлчилгээ явуулах зорилгоор 239 иргэн, ААН-ээс ирүүлсэн төслөөс 126 төслийг нь шалгаруулан банкинд хүргүүлсэн ба банк 95 иргэн, ААН-д 840.0 сая төгрөгийг буюу санд төвлөрсөн хөрөнгийг бүрэн зарцуулаад байна. Зарим төслийн тухайд ЖДҮ-ийг хөгжүүлэх санд төвлөрүүлэх хөрөнгө оройтож байршсан, харилцагч банкны үйл ажиллагаа, бусад хүчин зүйлээс шалтгаалан зээлийн олголтын явц удаашралтай байлаа. Төсөл амжилттай хэрэгжсэн тохиолдолд шинээр 34 үйлдвэр, үйл ажиллагаагаа 58 үйлдвэр өргөтгөх боломжтой болж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр шинээр гаргах худгийн тендерийг 4-р сард зарлаж, гүйцэтгэгчээр "Ус-Алтай" ХХК шалгарч Алтай сумд 1, Халиун сумд 2, Дарив сумд 2, Тонхил сумд 2, Цээл сумд 2, Цогт

сумд 2, Бугат сумд 2, Есөнбулаг сумд 1, инженерийн хийцтэй нийт 14 худаг гаргаж, улсын комисст хүлээлгэн өглөө. Мөн хугацаанд Эрдэнэ -8, Алтай-4, Бигэр-1, Дэлгэр -2, Тайшир-3, Тонхил-3, Халиун-1, Цээл-3, Цогт-2, Есөнбулаг-1, нийт 28 гар худгийг шинээр гаргасан.

Газрын доорхи усны хайгуулыг Усны хайгуул үйлдвэрлэл, эрдэм шинжилгээний “Оюунбадрах” ХХК улсын төсвийн хөрөнгөөр хийж, 1 сумд 4-5 уст цэг, бүгд 80 уст цэг тогтоосон.

Төгрөг сумын Далан түрүү 33.6 сая, Тонхил сумын Угалзын давааны 45,0 сая төгрөгийн өртөгтэй засвараар хөвүүдийг сэргээх төслийг мэргэжлийн байгууллагуудаар хийлгэж хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр Усны бодлогын хүрээлэнд хүсэлт тавиад байна.

Булаг шандын эхийг хашиж хамгаалах ажлын хүрээнд Бигэр сумын Уртын булаг, Халиун сумын Голын эхний Хойд булаг, Урд булаг, Чандмань сумын Шүрэн булаг, Шарга сумын Харганатын булаг, Цогт сумын Сухайтын булаг, Тайшир сумын Мөрөнгийн ам, Шар булаг, Тонхил сумын Тахилгатын булаг, Есөнбулаг сумын Олон нуур, Дөрөө булаг, Дарив сумын Усны эх булаг, Бугат сумын Майхан толгойн булаг, Төгрөг сумын Тахилгатын булаг, Дэлгэр сумын Хадатын рашаан зэрэг 15 булгийн эхийг хашиж хамгаалсан ажлыг аймгийн Засаг даргын 2009 оны 286 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг шалгаж, сумын Засаг даргын Тамгын газарт нь актаар хүлээлгэн өглөө.

Хүүхэд хөгжлийн сангаас 22114 хүүхдэд 789285.9 мянган төгрөг, шинэ төрсөн 1524 хүүхдэд 152400.0 мянган төгрөг, шинээр гэр бүл болсон 769 өрхөд 384500.0 мянган төгрөгийг хугацаанд нь иргэдэд хүндрэл чирэгдэлгүй олгоод байна. Нөхөрлөл, хоршооны хэлбэрээр ажиллах хүсэлтэй 284 иргэн, аж ахуйн нэгжид арилжааны банкуудаар дамжуулан 217.0 сая төгрөгийн 1.3 хувийн хүүтэй жижиг зээлийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгож, зээлийн үр дүнд 381 ажлын байрыг бий болгосон байна. Эдгээр зээлийн 184.7 сая төгрөг буюу 85.1 хувь нь хөдөө сумдад олгосон зээл байна.

## **2.2. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт**

Тайлант онд Ерөнхий сайдын захирамж 2, Засгийн газрын тогтоол 55, хуралдааны тэмдэглэл 20, Албан даалгавар 3, ирснийг хувийн хэрэг бүрдүүлж, хяналтын картанд бүртгэж холбогдох албан тушаалтнууд сум, байгууллагуудад хүргүүлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа.

2009 оны жилийн эцсийн мэдээгээр шинээр гарсан болон хуучин мөрдөгдөж байгаа Засгийн газрын 60 тогтоол, шийдвэрийн 80 заалтаас 100 хувь биелсэн 42, 90 хувь биелсэн 19, 70 хувь биелсэн 15, 50 хувийн биелэлттэй 4 тогтоол хяналтанд авсан тогтоол тэмдэглэл, албан даалгавар, Ерөнхий сайдын захирамжийн биелэлт ерөнхий дүнгээрээ 90.0 хувьтай хэрэгжсэн байна

Засгийн газрын тогтоол шийдвэрийн мэдээ тайланг ирүүлсэн хугацааны бүртгэл хөтөлж, улирал бүр Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж хэрэгжилт удааширалтай байгаа Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шалтгаан нөхцлийг судлаж хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар Засаг даргын дэргэдэх зөвлөлөөс хуралдааны тэмдэглэлээр үүрэг даалгавар өгснийг сум, агентлагуудад хувилан хүргүүлж ажиллалаа.

Орон нутгийн хэмжээнд Засгийн газрын тогтоол шийдвэрийг хэрэгжилтийг хангуулах, заавар зөвлөмж өгөх үүднээс сумдад архивын урьдчилсан үзлэгтэй хамтарч аймгийн ЗДТГ-ын баталсан удирдамжийн дагуу 5-н ажлын хэсэг гарч 18 сумын дотоод ажилтай танилцаж, Засгийн газрын тогтоолыг орон нутгийн хэмжээнд хэрхэн зохион байгуулж байгаатай танилцаж, хэрэгжилтийг эрчимжүүлэх илэрсэн дутагдал гажуудлыг засах арга хэмжээ авч заавар зөвлөгөө өгч илтгэх хуудасаар хэрэгжүүлэх ажлын жагсаалт өгч ажилласан.

Хууль зүйн хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу Эрүүл мэндийн газар, Стандарчилал хэмжил зүйн хэлтэст хэрэгжиж байгаа Засгийн газрын тогтоолийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж байгаатай танилцаж заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Сумдын ЗДТГ-ын дотоод ажил, Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан албан хаагчдад 2009 оны 6 дугаар сарын 23-ний өдөр шалгалтаар илэрсэн нийтлэг зөрчил дутагдлын талаар болон цаашид тогтоол шийдвэрийн биелэлтийг хэрхэн зохион байгуулах талаар 2 цагийн сургалт семинарыг зохион байгууллаа.

Хууль тогтоомж, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг сайжруулах, эрчимжүүлэх, хууль тогтоомж сурталчлах, тайлбарлан таниулах ажлын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхэд анхааран ажиллалаа.

Иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх, зорилгоор Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх тухай аймгийн Засаг даргын 2009 оны 03 дугаар албан даалгаварын дагуу нийт сум, байгууллагууд хуулийн сургалт, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулсанаар 7000 орчим хүн хамрагдсан байна.

Мөн байгууллага, аж ахуйн нэгжийн захиалга хүсэлтийн дагуу сургалтын төлөвлөгөө гарган байгууллага, аж ахуйн нэгжүүдэд Эрх зүйн хөтөч арга зүйн номын дагуу сэдэвчилсэн сургалтыг 16 удаа зохион байгуулж, 370 орчим хүн хамрагдлаа.

ГХУСАЗ зөвлөлтэй хамтран нийт сумдын болон аймгийн төвийн 4 багийн 11402 ард иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд авах арга хэмжээний 22390 ширхэг гарын авлага, санамж сэрэмжлүүлэг, анхааруулга, зөвлөмж тараан өгч ажиллаа. Аймгийн төвийн 4 баг, 102 байгууллага, аж ахуйн нэгжийг цагдаагийн алба хаагч нарт хуваарилан өгч давхардсан урьдчилан сэргийлэх ухуулга яриа хийсний зэрэгцээ 208 удаа 416 цагийн сургалт зохион байгуулж ажиллалаа.

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомжийг сурталчлах, иргэд олон нийтийг эрэлт хэрэгцээт шаардлагатай мэдээлэлээр хангах, тэдний хууль зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн олон нийтийн радио, Цахиур төмөр сонинтой эрх зүйн мэдээлэл сурталчилгааны ажлын чиглэлээр хамтран ажиллаж байна.

Аймгийн олон нийтийн Алтай радиогоор хуулийн мэдээлэл сурталчилгаа зохион явуулах төлөвлөгөөг аймгийн ГХУСАЗ33-ийн даргаар батлуулан мэдээлэл сурталчилгааны ажлыг долоо хоног бүрийн тусгай хуваарийн дагуу явуулж нийт 56 сэдвээр 56 удаа 280 минутын мэдээлэл, Миний нутаг телевизээр “Гэмт хэргээс урьдчилан сэргийлье” булангаар 24 удаа 240 минутын мэдээлэл явууллаа.

Цахиур төмөр сонинд 3 удаа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль, УИХ-аас шинээр батлан гаргасан хууль тогтоомжийн танилцуулга мэдээлэл бэлтгэж нийтлүүллээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын орон нутаг дахь миний нутаг телевизтэй байгуулсан гэрээний дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамнаас бэлтгэн ирүүлсэн “Хуулийн цаг”, төслийн нэгжээс ирүүлсэн “Хүний эрх” сэдэвт цуврал 72 удаагийн 1080 минутын нэвтрүүлгүүдийг долоо хоногт 2 удаа тогтмол нэвтрүүлж иргэд олон нийтэд сурталчиллаа.

УИХ-аас шинээр батлан гаргаж байгаа болон иргэдийн зайлшгүй мэдвэл зохих хууль тогтоомжийг нийт хүн амд цаг алдалгүй хүргэж сурталчлах хүртээмжийг нэмэгдүүлэх, үр дүнтэйгээр зохион явуулах зорилгоор Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх тухай аймгийн Засаг даргын 2009 оны 03 дугаар албан даалгавар, нийт нутаг дэвсгэрийн

хэмжээнд 2009 оны хагас жилд зохион явуулах Эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны хуваарийг аймгийн Засаг даргын 2009 оны 77 дугаар захирамжаар батлуулан нийт сум болон бүх шатны төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дарга, эрхлэгч нарт хүргүүлэн хэрэгжилтэнд нь хяналт тавин ажилласанаар хөдөө сумдад эрх зүйн мэдээлэл сурталчилгааны ажил тогтмолжиж, иргэд, малчдын эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх эрх зүйн албан бус сургалтыг зохион байгуулж хэвшсэн байна.

Аймгийн Засаг даргын 2009 оны 77 дугаар захирамжаар баталсан Эрх зүйн мэдээлэл сурталчилгааны нэгдсэн хуваарийн дагуу 13 хуулийн танилцуулга, мөн Улсын Их Хурлаас 2009 оны хаврын чуулганаар хэлэлцэн баталсан 8 хуулийн танилцуулгыг бэлтгэн 18 сум, 24 байгууллагад хүргүүлж сурталчилгааны ажилд ашиглаж байна.

2009 оны 12-р сарын 10-ны Хүний эрхийг өдрийг тохиолдуулан аймгийн Шүүх, Прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Эрх зүйн туслалцааны төвтэй хамтран иргэдэд “Хууль сурталчлах” нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж уг үйл ажиллагааг орон нутгийн Миний нутаг телевиз, ТВ-9 телевизүүдээр мэдээлж сурталчиллаа. Энэхүү нээлттэй хаалганы өдөрлөгөөр нийт 98 хүн хууль зүйн зөвлөгөө авч, 17 хүний санал, өргөдөлийг хүлээн авч шийдвэрлэж, хуулийн сэдэвт, иргэдийн эрхийн талаархи нугалбар хуудас, гарын авлага материал 1000 ширхэгийг бэлтгэж тараалаа.

Мөн иргэд, олон нийтийн дунд “Хүний эрх, хууль тогтоомжийн хэрэгжилт” сэдэвт илтгэлийн уралдаан зарлаж 9 илтгэл ирүүлсэнийг олон нийтийн өмнө өөрсдөөр нь илтгэлийг нь тавиулж 1, 2, 3, тусгай байр шалгаруулан 250.000 төгрөгөөр шагнав.

Жил бүр Хүний эрхийн сэдэвт дэвжээ уралдаант тэмцээнийг зохион явуулж хэвшсэн бөгөөд 2009 оны 12 сарын 10-ны өдөр нийт ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд 300000 төгрөгийн шагналын сантай “**Хүний хувийн эрх, эрх чөлөө**” сэдэвт дэвжээ тэмцээнийг зохион явуулж нийт 5 сургууль оролцсоноос 11 жилийн 2-р сургуулийн Эрх чөлөө баг 1-р, Анагаах ухааны коллежийн лицей сургуулийн Freedom баг 2-р, 3-р сургуулийн Халх монголын эзэд баг 3-р байрыг тус тус эзэллээ.

### **2.3. Монгол улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт**

Монгол улсын ерөнхий сайдтай аймгийн Засаг даргын 2009 онд байгуулсан батламжийн биелэлт 94.4 хувийн биелэлттэй байна. Монгол улсын Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг улирал бүр нэгтгэн гаргаж байна. Засгийн газрын тогтоолын заалт 83.6%, Ерөнхий сайдын захирамжийн заалт 100.0%, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн заалт 88.1%, Засгийн газрын албан даалгаврын заалт 90.0 хувьтай, нийт дүнгээрээ 90.4 хувиар биелсэн байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг мэргэжлийн байгууллагууд, сумын ЗДТГ-тай хамтран хуулийн хэрэгжилтийг шалгаж илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулахад онцгой анхааран ажиллаж байна. Тухайлбал архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн тоог орон нутгийн хүн амын тоонд нийцүүлэн шинэчлэн тогтоохтой холбогдуулж аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай, Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийг Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн хэлтэс, Стандартчилал хэмжил зүйн хэлтэстэй хамтран атестатчилах үзлэг шалгалтыг явуулж үзлэгээр 29 зөрчил илэрч зөрчлийг газар дээр нь арилгуулах арга хэмжээ авлаа.

Төрийн байгууллагын хүнд сурталыг багасгах төрийн үйлчилгээг ил тод хөнгөн шуурхай болгох үйл ажиллагаагаа нээлттэй болгох чиглэлээр 2009 оны “Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг

сайжруулах тухай” 02 тоот албан даалгавар, Засгийн газрын 2009 оны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай 143 дугаар тогтоолыг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж ажиллах талаар “Төлөвлөгөө батлах тухай “ аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2009 оны 36 дугаар тушаалаар “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө” боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг даалгаж тодорхой үүрэг даалгаваруудыг өгч ажиллаж байна.

2009 оны аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт заасны дагуу аймгийн татвар төлөгчдийн нэгдсэн тооллогын ажлыг зохион байгуулж татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын тоог 653-д хүргэж, урд оноос 1.6%-иар нэмэгдүүлсэн. Аймгийн санхүүгийн чадавхийг сайжруулах зорилгоор төсвийн зарлагад орлогын эзлэх хувь хэмжээг өнгөрсөн оноос 8.2 функтээр нэмэгдүүлж 68.3%-д хүргэлээ.

Нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг сахиулах, иргэдийн амгалан тайван, аюулгүй байдлыг хангахад аймгийн ГХУСАЗЗ, мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлэн ажиллалаа.

2009 оны 11 сарын байдлаар 112 гэмт хэрэг бүртгэгдэж урьд оны мөн үеийнхтэй харьцуулахад 59 хэргээр буюу 34.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 25 үйлдэгдсэнийг урьд оны мөн үеийнхтэй харьцуулахад 24 хэргээр буюу 48.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

#### **2.4. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт**

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн бүтэц агуулгыг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан тодорхойлсон бөгөөд нийт 4 бүлэгт 219 зорилт тавьж, хэрэгжүүлэх төлөвлөгөөг 564 зүйлтэйгээр боловсруулан аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулан ажиллаж байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтээс салбараар нь авч үзвэл Эрүүл мэндийн салбар 32.7 %, Боловсрол соёлын салбар 32.1 %, Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилт 31.1 %, Нийгмийн хамгааллын талаарх зорилт 25.0 %, Хүн ам зүйн талаарх бодлогын хэрэгжилт 46.1 %, Төсөв санхүү, эдийн засаг, татварын бодлогын хэрэгжилт 48.1 %, Үйлдвэржүүлэх бодлогын хэрэгжилт 33.2 %, Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилт 33.2 %, Дэд бүтэц, хот байгуулалтын бодлогын хэрэгжилт 37.2 %, Байгаль орчин аялал жуулчлалын талаар баримтлах бодлогын хэрэгжилт 36.9 %, Эрх зүйн бодлогыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын хэрэгжилт 41.3 %, Иргэний нийгэм, төрийн удирдлага, гадаад бодлогын хэрэгжилт 38.6 %, Орон нутаг, хил хамгалал, гамшгаас сэргийлэх бодлогын хэрэгжилт 39.3 хувь тус тус биелэсэн байна.

Аймгийн ИТХ-ын V хуралдаанаар Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг 36.5 хувийн биелэлттэйгээр “Хангалттай” гэж дүгнэлээ.

### **ГУРАВ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ.**

#### **3.1. Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт**

Өнгөрсөн 2009 онд салбарын төсвийн ерөнхийлөн захирагч сайдуудтай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулж, биелэлтийг улиралаар тооцон дүгнэж ажиллалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагч /сайд/ нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний биелэлтийг яамдын сайд тус бүрээр нь дүгнэвэл:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан гэрээний дагуу 4 бүтээгдэхүүний анги, 611655.4 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж 94.0 хувь
2. Батлан хамгаалахын сайдтай байгуулсан гэрээний дагуу 4 бүтээгдэхүүний ангийн 16 зорилтыг 100 хувиар биелүүлсэн.
3. Эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээний дагуу 6 бүтээгдэхүүний анги 88.6 хувиар биелүүлж, 5.303.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн.
4. Байгаль орчны сайдтай байгуулсан гэрээний дагуу 5 бүтээгдэхүүний анги 92.6 хувиар биелүүлж, 646183.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан.
5. БСШУ-ны сайдтай байгуулсан гэрээний дагуу 9 бүтээгдэхүүний анги, 90.5 хувиар биелүүлж, 6470.3 сая төгрөгийн санхүүжилт авсан.
6. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдтай байгуулсан гэрээний дагуу 5 бүтээгдэхүүний ангийн 20 зорилтыг 100 хувиар биелүүлж, 83.6 сая төгрөгийн санхүүжилт авсан.
7. ХХААХҮ-н сайдтай байгуулсан гэрээний дагуу 5 бүтээгдэхүүний анги зорилтыг 80.0 хувиар биелүүллээ.
8. Үндэсний статистикийн газрын даргатай байгуулсан гэрээний дагуу 4 бүтээгдэхүүний ангийн 14 зорилтыг 100 хувиар биелүүллээ.
9. Шадар сайдтай байгуулсан гэрээний дагуу Хүүхдийн байгууллага 3 бүтээгдэхүүний ангийн 13 зорилтыг 98.4 хувиар биелүүллээ
10. Тэргүүн Шадар сайдтай байгуулсан гэрээний дагуу Стандарт хэмжил зүйн төв 4 бүтээгдэхүүний ангийн 218 зорилтыг 100 хувиар биелүүллээ.

### **3.2. Төсвийн Ерөнхийлөн захирагчаас ерөнхийменежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт**

Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 187 дугаар тогтоолоор батлагдсан Төсвийн ерөнхийлөн захирагч ерөнхий менежертэй, ерөнхий менежер нэгжийн менежер /нэгжийн дарга/-тай үр дүнгийн гэрээ байгуулах болон тэдгээрийн биелэлтийг дүгнэх журмыг сум, агентлагуудад хүргүүлж, нэмэлт өөрчлөлтийн талаар байгууллагын дарга нарт зөвлөгөө өглөө. Шинэ журмаар 2009 оны гэрээг дүгнэж, 2010 оны үр дүнгийн гэрээг хийж байна.

Аймгийн ЗДТГ-ын ерөнхий менежер, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан 2009 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд **18** бүтээгдэхүүний ангиар, **40** бүтээгдэхүүн, **218** ажил үйлчилгээ тусган, гэрээнийхээ үүргийг **94.6%**-тай биелүүллээ.

Тус байгууллага нь 2009 онд орон нутгийн төсвөөс 525.2 сая төгрөг, цэрэг татлага дүйцүүлэхийн зардалд 6.0 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 11.4 сая төгрөг нийт 542.6 сая төгрөгийн татаас авч, өөрийн орлогод 1630.2 мян төгрөг оруулж, Санхүү эдийн засгийн бодлого зохицуулалтын хэлтсээс санхүүжүүлсэн цэрэг татлага дүйцүүлэхийн зардалыг өөрийн байгууллагаараа дамжуулан олгож тэдгээрийн зарцуулалтанд хяналт тавьж, 539.1 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийлээ.

Тайлант оны эцэст цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бичиг хэрэг, шуудан холбоо, албан томилолт, ном хэвлэл, нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардалуудыг хэмнэж, 5.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй, өргүй ажиллалаа.

## **ДӨРӨВ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ**

### **4.1. Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал**

Монгол улсын Засгийн газрын тогтоолын дагуу аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлагууд, төсөвт байгууллагууд үйл ажиллагаа, хууль сурталчилах, иргэдийн санал бодлыг нь сонсох, санал авах иргэдэд төрийн үйлчилгээг нэг цэгээс түргэн шуурхай хүргэх ажлыг зохион байгууллаа.

Нээлттэй хаалганы өдрөөр төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар иргэдээс санал авах хайрцаг, нээлттэй утас, mail хаяг, уулзалтын үед нийт 1641 санал хүсэлтийг хүлээн авсанаас 1183 санал хүсэлтийг нь газар дээр нь шийдвэрлэж хариу өгсөн байна. Энэ өдөр 4944 хүнийг оролцуулан 29 төрлийн 6540 ширхэг гарын авлага тараан үйл ажиллагаагаа сурталчилсанаас гадна орон нутгийн телевизээр мэдээлэл хүргэлээ.

Засгийн газрын тогтоолын дагуу “Нэг цонхны үйлчилгээ”-ний нээлтийн ажиллагааг зохион байгуулж төрийн байгууллагуудас иргэдэд үзүүлж байгаа төрөл бүрийн үйлчилгээний шат дамжлагыг цөөрүүлж, олон үйлчилгээг хүнд суртал чирэгдэлгүйгээр нэг дороос хүргэх болсонд иргэд талархаж байлаа.

Нээлттэй хаалганы өдрөөр иргэдэд хуулийн зөвлөгөө өгөх, иргэдийн бүртгүүлж баталгаажуулаагүй нэгж талбар газруудыг бүртгэлжүүлэн гэрчилгээжүүлэх, газрын мэдээллийн сангаар иргэдэд үнэ төлбөргүй үйлчилэх, албан бусаар хөдөлмөр эрхэлдэг иргэдийг үнэмлэхжүүлэх, хувиараа болон нөхөрлөл хоршооны хэлбэрээр жижиг зээл авч үйл ажиллагаа явуулах сонирхолтой иргэнд жижиг зээл олгох журмын дагуу хүсэлтээ гаргасан иргэдийг арилжааны банкуудаар дамжуулан судалж асуудлыг нь шийдвэрлэх, хөдөлмөр эрхэлж ажлын байр бий болгон өөрийн өрхийн орлогоо нэмэгдүүлэх хүсэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд гутлын иж бүрэн тоног төхөөрөмж олгох, хортой болон хугацаа хэтэрсэн чанаргүй бараа бүтээгдэхүүнийг сурталчилах зэрэг ажлуудыг зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр иргэдээс ирүүлсэн тухай үед нь шийдвэрлэх боломжгүй 458 санал хүсэлтийн хариуг өргөдөл гомдол шийдвэрлэх хуулийн дагуу хуулийн хугацаанд нь шийдвэрлэж иргэдэд хариу мэдэгдэхийг сум, агентлаг, албадын дарга нарт үүрэг болголоо.

2009 онд аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаан нийт 13 удаа хуралдаж 34 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Тайлант онд аймгийн Засаг даргын 351 захирамжийн 396 заалтыг хяналтанд авч хэрэгжилтийг тооцоход 90.0 хувийн биелэлттэй байна.

Байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор төрийн албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарьт хууль сурталчлагч байна гэж тусгаж өгсөн бөгөөд аймгийн Засаг даргын 2009 оны “Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах тухай 02 тоот албан даалгаварыг хэрэгжүүлэх зорилгоор үр дүнгийн гэрээнд тусган ажиллаж байна.

Төрийн албаны үйлчилгээг цахим программд шилжүүлэх бэлтгэлийг ханган интертэтэд холбогдсоноор шаардлагатай мэдээллээ авч байгаагаас гадна дотоод сүлжээ ашиглалтыг

нэмэгдүүлснээр өөр хоорондоо бичиг баримтыг сүлжээгээр дамжуулан харилцаж байгаа нь цаас хэрэглэх явдлыг багасгаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 41 компьютер нь дотоод сүлжээнд холбогдож хоорондоо бичиг баримт мэдээлэл дамжуулан сүлжээгээр харилцаж байна.

Аймгийн Засаг даргын 2009 оны “Ажил дүгнэх тухай” 327, 328 дугаар захирамжаар сум, агентлагийн ажлыг дүгнэх журмыг шинэчлэн, сум агентлагийн ажлыг шалгаж үнэлгээ шинжилгээ хийлээ. Засаг даргын дэргэдэх агентлагуудыг 4 бүлэг 20 шалгуур үзүүлэлтээр, сумдын Засаг даргын Тамгын газрын ажлыг 8 бүлэг 102 шалгуур үзүүлэлтээр дүгнэлээ. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 20 агентлагийн 1 нь маш сайн, бусад агентлаг хангалттай, 18 сумын Засаг даргын Тамгын газрын 3 хангалттай, бусад сум дутагдалтай дүгнэгдэж, 2009 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээгээ сум, агентлагууд амжилттай биелүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын ТЗУХэлтэст Хяналт шинжилгээ үнэлээний тасгийг байгуулан ажиллаж байна. Тайлант онд тус тасаг давхардсан тоогоор 12 сумын үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ хийж зөвлөмж өгсөн. Аймгийн сум, агентлаг, хэлтсийн жилийн ажил дүгнэх журмыг өөрчлөн, Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж батлууллаа. Аймгийн жишиг сум, баг шалгаруулах журмыг боловсруулан, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулан батлууллаа.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг зохион явуулах тухай Монгол Улсын Ерөнхий сайдын 37 дугаар захирамжийн дагуу аймгийн Засаг даргын 2009 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 141 дүгээр захирамжаар аймгийн Засаг даргын тамгын газрын даргаар ахлуулан 18 хүний бүрэлдэхүүнтэй салбар комиссыг байгуулж, салбар комиссын төлөвлөгөөнд 14 ажил тусгагдаж, 100 хувь биелэгдлээ.

Үзлэгт хамрагдсан байгууллагуудад архивын байнга хадгалах 8845 хадгаламжийн нэгж, түр хадгалах 15583 хадгаламжийн нэгж байгаа бөгөөд эдгээр архивын баримтууд нь 825.5 м<sup>2</sup> талбайд 237 метр урттай тавиур шүүгээнд тус тус хадгалагдан ашиглагдаж байна.

Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Тамга тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар”-ын дагуу байгууллагад хэрэглэгдэж байгаа тамга, тэмдэгийн ашиглалт, хадгалалтын байдалд үзлэг явуулж, дардасыг авч нэгтгэн дүгнэж, албан хэрэгт ашиглагддаг бичгийн нүүр дардасыг шинэчлэн хийлгүүлээ.

Архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай аймгийн Засаг даргын 2009 оны 08 сарын 14-ний өдрийн 227 дугаар захирамжаар сум, байгууллагын үзлэгийн дүнг баталж, дутагдалтай буюу хангалтгүй үнэлгээ авсан байгууллагуудад хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг 8 сарын 25-ны дотор өөрийн зардлаар дахин дүгнүүлэхийг холбогдох сум, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт даалган, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газар, салбар комисст үүрэг болгосоны дагуу 39 байгууллагад давтан үзлэг явуулж дүгнэлээ.

Үзлэгийн арга хэмжээний талаар “TV-9”, аймгийн “Миний нутаг” телевизээр тус бүр 1 удаа, Архивын Ерөнхий газрын веб сайтуудад тухай бүрт нь мэдээлэлийг өгч, олон нийтэд мэдээлж ажиллав.

Аймгийн салбар комиссоос 169 байгууллагад үзлэг явуулж, улсын үзлэгийг зохион байгуулах төв комиссын үзлэгт Дэлгэр, Есөнбулаг сумдын Засаг даргын тамгын газар, Боловсрол соёлын газар,

Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, аймгийн Засаг даргын тамгын газар зэрэг байгууллага хамрагдаж, үзлэгийн дүнгээр 96, 8 буюу “А” үнэлгээтэй дүгнэгдэж улсын хэмжээнд аймгийн ЗДТГ 3-рт шалгараад байна.

Аймгийн ИТХ, ба бусад аймгийн хэмжээний томоохон хурал цуглааныг орон нутгийн радио нэвтрүүлгээр шууд дамжуулан хөдөлмөрчдөд мэдээлж байна.

Өнгөрсөн онд төр, захиргааны байгууллагын ажлын талаар аймгийн радио нийт 132 удаагийн 66 цагийн нэвтрүүлэг бэлтгэн явуулсан байна. Аймгийн радиогийн нэвтрүүлгээр “Төр, засгийн индэр”, “Хууль эрх зүй”, “Засаг даргын цаг” зэрэг байнгын булантай болж, төр захиргааны байгууллагын удирдлагууд дэвшүүлсэн зорилт, авах арга хэмжээ, хүрэх үр дүнгээ дэлгэрэнгүй ярьж, иргэддээ ойлгуулан нийтийн санаа бодлыг сонсож, ажилдаа тусгадаг болон хэвшээд байна. Аймгийн албан газар, агентлагуудын дарга нарын зөвлөгөөнийг 7 хоногийн 1 дэхь өдөр хийж, өөрсдийн салбарын чиглэлээр мэдээлэл солилцон, аймаг оронд тулгамдаж байгаа асуудлын талаар хэлэлцэж хэвшээд байна.

“Миний нутаг” телевизэд төрийн захиргааны байгууллагууд 7 хоног бүр хийсэн ажлаа иргэдэд сурталчилж мэдээлж байна. Орон нутгийн радиогоор, болон, долоо хоногийн 1 дахь өдөр болгон зохиогддог албан байгууллагын дарга нарын цуглаан дээр аймгийн удирдлагууд, хэлтэс, агентлагын дарга нар Монгол улсын хууль, Засгийн газрын тогтоол, шийдвэр, аймгийн удирдах байгууллагын бодлого, шийдвэр, цаг үеийн ажлаар тогтмол мэдээлэл хийж, орон нутгийн “Цахиур төмөр” сонинд байнгын булан нээж, сар тутам сурталчилгааны материал нийтэлдэг бөгөөд 2009 оны Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагаа, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Нийгэм, Эдийн Засгийн хөгжлийн дүн, 2010 оны зорилтыг сурталчлан сонины бие даасан дугаар гарган ажиллаж байна.

Мөн төр, иргэний нийгмийн байгууллагууд болон хувийн эвшлийнхний “Гурван талт түншлэл”-ийн сургалт, зөвлөгөөнийг аймагт зохион байгуулж, уг сургалтанд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн нийт 90 гаруй хүмүүс оролцлоо. Зөвлөгөөний үр дүнд нь төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээг нээлттэй, ил тод, шударга, чирэгдэлгүй, шуурхай болгох, иргэний нийгмийн байгууллагуудыг чадваржуулж бэхжүүлэх, уялдаа холбоог сайжруулах, орон нутгийн төсвийн бодлогыг тухайн орон нутгийн хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэгдсэн арга механизмыг бий болгох болон эдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгоход чиглэгдлээ.

#### **4.2. Хүний нөөцийн ил тод нээлттэй байдал**

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйл, журмын дагуу төрийн захиргааны албаны удирдах албан тушаалтны сул орон тоо гарсан үед нь сонгон шалгаруулалтыг зарлаж, төрийн албаны салбар зөвлөлийн тогтоолоор байгуулсан комисс шалгаруулалтыг зохион байгуулж байна. Тайлант онд Бигэр, Чандмань, Бугат, Алтай, Баян-Уул, Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын даргын, Алтай, Бугат, Тайшир, Тонхил, Төгрөг, Цогт, Цээл, Чандмана, Эрдэнэ сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн нарийн бичгийн даргын, аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын, Нийгмийн хөгжлийн хэлтсийн даргын, Хөгжлийн бодлогын хэлтсийн даргын, Эрүүл мэндийн газрын орлогч даргын, Нэгдсэн эмнэлгийн даргын, Биеийн тамир спортын газрын даргын нийт 21 удирдах албан тушаалд сонгон шалгаруулалт явууллаа.

Сонгон шалгаруулалтад нийт 60 хүн орж , 36 хүн буюу шалгалтанд орсон иргэдийн 60.0% нь тэнцсэн. Төрийн албаны салбар зөвлөлийн хурлаар комиссын дүнг хэлэлцэн, ажлын байрны шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа төрийн албан хаагчийг эрх бүхий албан тушаалтанд нь томилуулах санал хүргүүлж, шийдвэрлүүлсэн. Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын, Нийгмийн хөгжлийн хэлтсийн даргын албан тушаалд төрийн албаны тухай хуулийн 17 зүйлийн 17.1 –ээр, Биеийн тамир спортын газрын даргын албан тушаалд нөөцөөс эрх бүхий албан тушаалтанд санал болгож, томилуулсан.

Сонгон шалгаруулалтын үр дүнг хүлээж авсан эрх бүхий албан тушаалтан төрийн албаны тухай хууль, сонгон шалгаруулалт явуулах журмын хугацаанд хариу ирүүлэхгүй, ирсэн албан бичгийн үндэслэл тодорхой бус зэргээр олон хоногоор ажил цалгардуулж байсныг тэмдэглэж байна. Энэ байдал Тайшир, Эрдэнэ, Алтай сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын, Бигэр сумын ЗДТГ-ын даргын албан тушаалын сонгон шалгаруулалтын явцад гарсан. Эрдэнэ, Бигэр, Цогт сумд төрийн албаны салбар зөвлөлийн гишүүд ажиллаж асуудлыг газар дээр нь шийдвэрлэсэн.

Төрийн албаны мэргэшлийн шалгалтаар нөхөгдөж чадаагүй болон шинээр гарсан ажлын байрыг төрийн албанд анх орох иргэний нөөцөөс нөхөх ажлыг журмын дагуу тухай бүрд нь хийж байна. 2006 онд 10 байгууллагын 11, 2007 онд 5 байгууллагын 5, 2008 онд 12 байгууллагын 15, 2009 онд 20 байгууллагын 25-н шинээр гарсан ажлын байранд төрийн албанд анх орох иргэний нөөцөөс судалж, ажилд авчээ.

Төрийн албанд анх орох нөөцөнд бүртгэлтэй иргэдийн 2008 оны нөөцөд бүртгэлтэй 157 иргэний 130 буюу 82.0% нь, 2009 оны нөөцөд бүртгэлтэй 58 иргэний 43 буюу 74.0% нь ажилд орсон болно. Төрийн албаны хүний нөөцийн мэдээлийн санг 22 байгууллага, 18 сумдад судалгааг компьютерт суулган өгснөөр төрийн албан хаагчийнхаа мэдээллийг байнга баяжуулах, тоо баримтыг ашиглах боломжоор бүрэн хангагдсан болно.

Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн сангийн тоо бүртгэлийг зохион байгуулах талаар гарын авлага материал, зөвлөмжийг боловсруулан сум, агентлагт хүргүүлээ. Мэдээллийн сангийн технологийн аюулгүй байдал, нууцлалыг хангах, боловсон хүчний хэрэгцээ, сургалт, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тоо баримтыг ашиглахад зөвлөмжийн зорилгыг чиглүүлсэн болно.

Төрийн удирдах болон захиргааны албан хаагчийн мэргэшүүлэх, давтан сургах ажлыг Удирдлагын Академийн сургалтын болон дотоодын сургалтын хөтөлбөрөөр зохион байгуулж байна. Удирдлагын Академийн тэтгэлэгт, төлбөртэй мэргэжил олгох сургалтанд жил бүр элсэлт хийж, төрийн албан хаагчийг мэргэшүүлж байна Удирдлагын академийн төр, нийгэм, бизнесийн удирдлагаар мэргэшүүлэх сургалтанд 18 төрийн албан хаагчийг сургахаар элсэлт хийж, гэрээ байгууллаа. Мөн хандивын ангид 24 хүнийг элсүүлэх асуудлыг шийдвэрлэв.

Тайлант онд аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын дарга болон мэргэжилтэн, бизнесмений төлөөлөгч, Бигэр, Шарга сумын Засаг дарга зэрэг 16 төрийн албан хаагч, БНСУ, БНХАУ, ӨМӨЗОронд гэрээ хэлэлцээ хийх, туршлага судлах, сургалт, мэргэжил дээшлүүлэхэд гадаад арга хэмжээний зардлаас 9.7 сая төгрөг зарцууллаа.

Дотоодын сургалтыг аймгийн ЗДТГ-ын сургалт, семинарын төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр болон салбарын чиглэлээр зохион байгуулж байна. Аймгийн ЗДТГ-ын 2009 оны сургалт семинарын төлөвлөгөөний дагуу 36 удаа 3422 төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан хаагчийг сургалт семинарт хамруулж, мэдээлэл өгсөн болно.

#### **4.3. Төсөв, санхүүгийн ил тод байдал.**

2009 онд дэлхий нийтээрээ эдийн засгийн хямралд автаж дотоод нөөц бололцоогоо бүрэн дайчлан ажиллаж, орлогоо нэмэгдүүлэх, зарим талаар төсвийн зарлагаа хязгаарлах шаардлага тулгарсан онцлог жил болон өнгөрлөө.

Аймгийн хэмжээгээр энэ онд нийт 3916781.1 мянган төгрөгийн зарлага санхүүжилт хийж , 1117102.7 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, орон нутгийн төсвийн орлогод 2790061.8 мянган төгрөг оруулж төлөвлөгөөг 105.2 хувиар биелүүлсэн байна.

УИХ-аас төсвийн зарлагыг бууруулж, тодотгон манай аймгийн орон нутгийн төсвийн зарлагын дээд хэмжээ анх төлөвлөснөөс 1.4 тэрбум төгрөгөөр хасагдсан. Энэ онд нийтдээ 3 удаа төсвийн тодотгол хийж аймгийн ИТХ-аар батлууллаа.

Малчин өрх, мал бүхий иргэний орлогын албан татварыг 7-р сарын 16-наас чөлөөлсөнтэй холбогдуулан Сангийн яамнаас ирсэн чиглэлийн дагуу малчин өрх, мал бүхий иргэний орлогын албан татварын орлогын төлөвлөгөөг 2009 оны ногдуулалтын 50 хувиар тооцон өмнө батлагдсан төлөвлөгөөний зөрүүгээр бууруулж, цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын 11 сарын гүйцэтгэлийн мэдээ болон бусад тооцоог үндэслэн төлөвлөгөөг нэмэгдүүлж, Эрдэнэ сумын ан амьтан агнах барих зөвшөөрлийн хураамжийг орлогыг бууруулах Сангийн яамнаас өр барагдуулахад зориулан олгосон 108432.7 мянган төгрөгийг сум байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, 11 сарын зарлагын болон өглөгийн мэдээг үндэслэн хуваарилж аймгийн ИТХ-аар батлуулан төсвийн нэгдсэн дүнг Сангийн яаманд хүргүүлж санхүүгийн тайланд бүрэн тооцож тусгасан.

2009 оныг “Санхүүгийн ажилд сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарлаж, төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, батлагдсан төсөвтөө багтаан өр, авлага үүсгэхгүй ажиллахыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн менежерүүдэд даалгасан аймгийн Засаг даргын 01 тоот албан даалгавар гаргуулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллалаа.

Төрийн өмнөөс зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх төрийн бус байгууллагуудын саналыг авч нэгтгэн нийлүүлэх бүтээгдэхүүн, өртөг, шалгуур үзүүлэлтийг тохирон гүйцэтгэлээр санхүүжүүлсэн байна.

Аймгийн аудитын газраар аудит хийгдэж залруулга хийгдсэн төсөвт байгууллагуудын 2008 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, сумдын төсвийн ерөнхийлөн захирагчийн бүтээгдэхүүн нийлүүлэлтийн нэгтгэсэн тайланг нэгтгэж, хуулийн хугацаанд нь Сангийн яаманд тушаасан байна.

2008 оны улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын орлого, зарлага, өр, авлага, хөрөнгө оруулалт, шилжих үлдэгдлийн нэгтгэлийг гаргаж удирдлагад танилцуулан шилжих үлдэгдлийн тооцоог хийж аймгийн Засаг даргын 97 тоот захирамжаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 40.0 сая төгрөг, улсын төсвийн байгууллагуудад 128.9 сая төгрөгийг зарцуулах эрх олгов.

2009 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 45.9 сая, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 765.0 сая, их засварт 171.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгов.

2010-2012 оны төсвийн хүрээний мэдэгдлийг сум байгууллагуудаас авч нэгтгэн, Сангийн яаманд хүргүүлэв.

Улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр хугацаанд нь гаргаж сангийн яаманд дамжуулсан төдийгүй статистикийн хэлтсийн танилцуулгад оруулж мэдээлсэн.

2008 оны улсын найдвартай татвар төлөгчөөр Мандал-Голомт ХХК, аймгийн найдвартай төлөгчөөр Ентүм ХХК, Зост-Өндөр ХХК –ууд шалгарсан байна.

Аж ахуй нэгж байгууллагуудын 2009 оны санхүүгийн тайланг батлагдсан маягт аргачлалын дагуу авч нэгтгэн Сангийн яаманд төрийн сангийн сүлжээгээр дамжуулсан ба нэгтгэлд ХК-2, ХХК -141, ББН-14, ЗБН-11, Хоршоо-73, ТӨҮГ-2, ОНӨҮГ-11, Олон нийтийн болон төрийн бус байгууллага 8, бүгд 266 байгууллага хамрагдаж нийт тайлан тушаалт 95 хувьтай байна. Үүнээс 23 байгууллага тайлангаа аудит хийлгэж баталгаажуулсан байна.

Аймгийн Татварын хэлтэс нь үндэсний татварын албанаас 2009 оныг “Цахим үйлчилгээг өргөжүүлж, бүртгэлийг төгөлдөршүүлэх” жил болгосон зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлэх ажлын хүрээнд, ҮТЕГ-аас 2009 онд хийх ажлын үндсэн чиглэл, стандарт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2009 онд нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн дагуу үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд 7 бүтээгдэхүүний ангийн хүрээнд 46 зорилттой, 148 үйл ажиллагааг хийхээр тусган хэрэгжилтийг зохион байгууллаа. Улсын бүртгэлд 646 ААНБ байснаас шинээр 26 нэмэгдэж, 44 хасагдаж одоогоор 628 ААНБ байгаа нь 18-р буурсан байна. Хөрөнгийн татвар төлөгч ААНБ болон иргэн 9563 байснаас 10151 болж 588-аар нэмэгдсэн ба АТБӨЧХАТ төлөгчийн тоо 797, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгчийн тоо 11-р буурсан байна.

Улсын төсвийн орлогын 450600.0 мянган төгрөгийн төлөвлөгөөг 521657.5 мянган төгрөгөөр буюу 115.7 хувиар биелүүлж, орлогын төлөвлөгөөг давуулсан. Орон нутгийн төсвийн орлогын 26079720.0 мянган төгрөгийн төлөвлөгөөг 2752591.4 мянган төгрөгөөр буюу 105.5 хувиар биелүүлж, 5.5 хувь буюу 144619.4 мянган төгрөгөөр давуулж ажилласны үр дүнд нийт дүнгээр 3058371.7 мянган төгрөгний төлөвлөгөөг 32742450.6 мянган төгрөгөөр буюу 121.8 хувиар биелүүлж, нийт дүнгээр 21.8 хувь буюу 417321.0 мянган төгрөгөөр давуулсан байна.

Аймгийн төрийн сан нь 2008 оны жилийн эцсийн орон нутгийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 17 сум, 2 багийн 58 байгууллагын, улсын төсвийн нэгтгэсэн тайланд 9 төсвийн ерөнхийлөн захирагчийн 118 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж гаргалаа.

Сумдын төрийн сангийн төлөөлөгч, шууд харилцагч улсын болон орон нутгийн төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарын 2008 оны төсвийн жилийн ажлыг дүгнэж, цаашдын зорилтын талаар сургалт семинар зохион байгууллаа.

Сумдын төрийн сангийн төлөөлөгчийг сумдын төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран сумдын төрийн сангийн төлөөлөгч нарыг томилон, үлгэрчилсэн ажлын байрны тодорхойлолт гаргаж сумдад хүргүүлэн арга зүйгээр ханган ажиллаж байна.

Засгийн газрын удирдлага мэдээллийн системд 4 сараас эхлэн Есөнбулаг сумыг холбож үйл ажиллагааг тогтмолжууллаа. Жаргалан, Тайшир сумд сүлжээнд холбогдож 2010 оны 1 сараас эхлэн үйл ажиллагааг эхлүүлж төлбөр тооцоог төрийн сангийн нэгдсэн сүлжээгээр хийхэд бэлэн болсон.

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн дахин үнэлгээ хийх сургалтын зохион байгуулж, нийтийн ерөнхий үйлчилгээний салбарын дахин үнэлгээг хийж нэгтгэлийг хийлээ.

Сангийн сайдын 2009 оны 147-р тушаалаар батлагдсан “Төсвийн зарцуулалтын болон зарцуулалтын эрхийн тухай” журам, “Төсвийн урсгал зардлын зүйл дотор зохицуулалт хийхэд мөрдөх” журмуудыг сум байгууллагад хүргүүлэн хэрэгжүүлэн ажилласан. Аймгийн төрийн сан төсвийн урсгал зардлын зүйл дотор гүйлгэн зарах хүсэлт ирүүлсэн 23 байгууллагын санал хүсэлтийг хүлээн авч хянан журмын дагуу шийдвэрлэлээ.

Аймгийн МХГазарын санхүүгийн хяналт шалгалтын хэлтэстэй хамтран ажиллаж, ажил төрлийн уулзалт зохион байгуулж, зарим нэг зөрчлийг хурдан шуурхай арилгах, зарим актын төлбөрийг барагдуулахад хамтран ажилласан болно.

Аймгийн төрийн сантай шууд харицагч байгууллагуудын кассын орлогыг заавал харилцах дансанд тушааж бүртгэлд тусгах зарчмыг баримталж кассын тайланг сар бүр авч хэвшсэн байна.

#### **4.4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал**

2009 онд аймгийн хэмжээнд 12.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, их засварын ажил хийгдсэнээс Монгол улсын хөгжлийн сан, улсын төсвийн хөрөнгөөр 67.2% нь буюу 8069.4 сая төгрөгийн, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1.5% нь буюу 177.5 сая төгрөгийн, аймагт хэрэгжиж байгаа 12 төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр 23.3% нь буюу 2812.8 сая төгрөгийн, хувийн хөрөнгөөр 5.8% нь буюу 701.6 сая төгрөгийн, бусад эх үүсвэрээс 2.2 хувь буюу 262.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хэрэгжээд байна.

Шинээр барих, их засвар хийх барилга байгууламжийн 14 ажлын худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгууллаа.

Он дамжин хэрэгжиж буй хөрөнгө оруулалтаас "Алтай" чуулга, Уламжлалт Анагаах ухааны төв, Татварын хэлтсийн барилга, Цогт сумын сургуулийн дотуур байрны өргөтгөл, Нэгдсэн эмнэлгийн барилгын их засварын ажил энэ онд үргэлжилнэ.

Төгрөг сумын соёлын төвийн барилгын ажил үндсэндээ дууссан боловч гүйцэтгэгч хөрөнгө дутсан гэсэн шалтгаанаар ашиглалтанд хүлээлгэн өгөөгүй, Алтай хотын төвийн хатуу хучилттай 2 км автозамын шинэчлэлийн ажил хийгдээгүй байна.

Хөрөнгө оруулалтыг салбараар нь авч үзвэл: **Боловсролын салбарт** 2316.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс шинэ барилга байгууламжид 1545.9 сая, их засварт 482.2 сая, техник тоног төхөөрөмж авахад 39.1 сая, бусад арга хэмжээнд 249.6 сая төгрөг зарцуулжээ.

Урьд оноос үргэлжлэн баригдсан Чандмань сумын цэцэрлэг, Бигэр, Дарив, Дэлгэр сумдын соёлын төвийн барилга /4/, Халиун сумын сургуулийн дотуур байрууд, Жаргалан сумын сургуулийн хичээлийн байр, Есөнбулаг сумын II сургууль, IY цэцэрлэг, АУК-ийн хичээлийн байр, Дарив сумын сургуулийн дотуур байр, гал тогооны барилга зэрэг 9 барилгад засвар хийж ашиглалтанд оров.

**Эрүүл мэндийн салбарт** 1366.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс шинэ барилга байгууламжид 467.2 сая, их засварт 465.8 сая, техник тоног төхөөрөмж авахад 379.0 сая, бусад арга хэмжээнд 54.0 сая төгрөг зарцуулжээ.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилгын их засварын ажлыг 2009-2010 онд АХБ-ны "ЭМСХХ-3" төслийн 738.8 сая төгрөгийн санхүүжилтээр хийгдэж, Жаргалан сумын эмнэлгийн эхчүүдийн амрах байр, Байгалийн голомтот ХӨТГ-ын худаг, лабораторийн барилга, Спорт цогцолборын барилга зэрэг 7 барилгад засвар хийж гүйцэтгэв.

Тонхил, Хөхморьт, Цээл, Халиун, Дэлгэр, Төгрөг, Жаргалан сумдын эмнэлэгт түргэн тусламжийн УАЗ-469, Нэгдсэн эмнэлэг Аксент маркийн-2, УАЗ-22069 маркийн -1, DPA ниссан маркийн -1 автомашинаар парк шинэчлэлт хийв.

Алтай, Бигэр сумдын эмнэлэгт НҮБ-ын ХАС-ын төслөөс 72.9 сая төгрөгийн багаж, тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна.

**Хүнс, хөдөө аж ахуйн салбарт** 2636.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс шинэ барилга байгууламжид 1045.4 сая, их засварт 212.2 сая, техник тоног төхөөрөмж авахад 17.3 сая, бусад арга хэмжээнд 1361.6 сая төгрөг зарцуулжээ.

Улсын төсвийн 230.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 сумд 16 худаг шинээр гаргаж, Бигэр сумын Мянгайн усалтын систем, Цогт сумын Хаяагийн усалтын системийн толгойн барилгын засваруудыг хийж гүйцэтгэлээ. ХХААХҮЯамнаас зарласан усны хайгуулын тендерт Усны хайгуул, үйлдвэрлэл, эрдэм шинжилгээний “Оюун бадрах” ХХК шалгарч уст цэг тогтоох геофизикийн хайгуулын ажлыг хийж 80 уст цэг тогтоогоод байна.

"Мерси кор" ОУ-ын байгууллагаас ХХААЖДҮГ-ын Мал эмнэлгийн лабораторит шинжилгээний багаж төхөөрөмж, компьютер техник хэрэгслийг олголоо.

**Байгаль орчны салбарт:** Байгаль орчны бохирдлыг багасгах, булаг шандын эх хамгаалах, ойжуулалтын арга хэмжээнд 85.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс техник тоног төхөөрөмж авахад 20.8 сая, бусад арга хэмжээнд 64.3 сая төгрөг зарцуулжээ.

**Дэд бүтцийн салбарт** 5746.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс шинэ барилга байгууламжид 5266.5 сая, их засварт 147.9 сая, техник тоног төхөөрөмж авахад 115.1 сая, бусад арга хэмжээнд 216.7 сая төгрөг зарцуулжээ.

Алтай, Бугат, Цээл сумдын болон Баянтоорой багийн төвийн 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах шугам шинэчлэх ажлыг хийж дууслаа. Бугат сумын нарны цахилгаан станцын эх үүсгүүрийн хүчин чадлыг 80 кВт-аар нэмэгдүүлэх ажлыг “Ньюпаур” ХХК, Алтай сум /202,5квт/, Баянтоорой тосгонд /102,6квт/ нарны цахилгаан станц байгуулах ажлыг "Коисиро", "Малчин трейд" ХХК-иуд гүйцэтгэж байна.

Нисэх онгоц хөөрч, буух хатуу хучилттай 2,9 км зурвас хийх ажлаас онгоц түр буух 2.3 км нягтруулсан шороон зурвас, үерийн далан барих ажил дуусч ашиглалтанд орсон бөгөөд 60 см ухмалын ажил, I үеийн 30 см суурийн ажлыг тус тус хийж энэ оны энэ оны ажил дууссан.

Засгийн газрын бондын санхүүжилтээр аймгийн төвд Төрийн албан хаагчийн 20 айлын орон сууц, амины орон сууцны “Хөгжил” хорооллын инженерийн шугам сүлжээг орон нутгийн төсвийн санхүүжилтээр өргөтгөн иргэдэд газар олгосноор энэ онд 11 иргэн хувийн хөрөнгөөр орон сууц, Тайшир сумд ХААН банкны салбарын барилга баригдаж дуусан ашиглалтанд орлоо.

УИХ-ын гишүүний тойрогтоо зарцуулах хуваарьт төсвийн 152.8 сая төгрөгийн санхүүжилтээр Есөнбулаг сумын төвийн 6 км гудамжийг, “ТА-II” төслийн 8.0 сая төгрөгийн санхүүжилтээр Харзат багийн гудамжийг гэрэлтүүлэгтэй болгох ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтанд оруулсан.

“Шинэ эрин Залуучууд хөгжил төв” ТББ, Франц улсын “АРЕЕД” ТББ хамтран Төгрөг сумын төвийн усан хангамжийг сайжруулах төслийн хүрээнд гүний худаг шинээр гаргаж, 3 ус түгээх байр барьж, ашиглалтанд оруулаад байна.

**Орон нутгийн төсвийн** санхүүжилтээр Алтай хотын ундны усны нөөц нэмэгдүүлэхээр Харзатын районд 120 м гүн худаг шинээр гарган ашиглалтанд орууллаа.

Замын сангийн хөрөнгийг төвлөрүүлэн 114.5 сая төгрөгийн санхүүжилтээр Дарив сумын төвийн модон гүүрний засвар, Есөнбулаг сумын Дөтийн давааны 12 км хайрган замын засвар болон Жаргалант багт 2.2 км сайжруулсан хайрган зам шинээр барих ажлуудын зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж зураг төсвийг нь бэлэн болгосноос Жаргалант багт зорчигч тээврийн үйлчилгээ явуулах зорилгоор 2.2 км сайжруулсан хайрган замыг барьж ашиглалтанд

орууллаа. Мөн хотын доторхи хатуу хучилттай замд засвар арчлалт хийж 278 м2 нөхөөсийн ажлыг "ГА-А33А" ХК гүйцэтгэв.

Эмнэлэгийн тоног төхөөрөмж, эм ханган нийлүүлэх тендрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулав. Тендерт 10 байгууллага оролцсон ба Эм-импекс ХХК, Евро-Фарм ХХК, Мон-лав ХХК, Юунитест ХХК, Мон-фа, Авайко ХХК, Мон сам ХХК, Цомбо ХХК, Нахиа импекс ХХК-ууд шалгарч эм, эмнэлэгийн тоног төхөөрөмжийг ханган нийлүүлэхээр гэрээ хийсэн байна. Тендрийн эмийн зардлыг тусгай дансанд төвлөрүүлэн санхүүжилтэнд хяналт тавьж байна

## **ТАВ: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДАГВАРЫН ҮНЭЛГЭЭ**

### **5.1. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ**

#### ***Хүн ам зүй, хөдөлмөр, нийгмийн хамгааллын талаар***

Хүн ам, орон сууцны 2010 оны ээлжит тооллогыг зохион байгуулж явуулах аймгийн түр товчоо болон сумын тооллогын комиссыг Аймгийн Засаг даргын 2009 оны 155 дугаар захирамжаар батлан холбогдох газар, сумдад хүргүүлээ. Тус захирамжийн дагуу бүх сумд сумын болон багийн тооллогын түр товчоог байгуулаад байна.

Аймгийн хүн амын талаар 2010 он хүртэл баримтлах бодлогын хэрэгжилтийн хүрээнд сум бүр өөрийн онцлогт тохирсон хүн амын бодлоготой болж, хүний хөгжлийг хангахад шаардагдах ажлын чиглэлийг тодорхойлон хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Говь-Алтай аймгийн хүн ам 2009 оны жилийн эцэст 55426 болж өмнөх оноос 48 хүнээр, хөдөлмөрийн насны хүн ам 33856 болж 89 хүнээр тус тус өссөн байна.

2009 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 996 болсон ба ажилгүйдлийн түвшин 4.0 хувьтай байна.

Орон даяар бий болсон эдийн засгийн хямралын улмаас аймгийн эдийн засаг, нийгэм, хувийн хэвшлийн салбарт ажиллагсдын тоо 24061 болж өнгөрсөн оноос 422 хүнээр буурсан нь ажилгүйчүүдийн тоо өсөхөд нөлөөлж эдийн засгийн идэвхитэй хүн ам 25057 болж 1.6%-иар буурсан бол хөдөлмөр эрхэлдэггүй хөдөлмөрийн насны хүн ам өмнөх оноос 249 хүнээр нэмэгдэж 3274, хөдөлмөрийн насны суралцагсад өсч 4863 болж, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй 1017 хүн байна.

Эдийн засгийн өсөлтийг дэмжих, бага орлоготой өрхийн тоог бууруулах чиглэлээр ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн нийт 1433 ажлын байрны захиалгын дагуу ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн 1382 хүнийг ажилд зуучилж ажлын байртай болголоо.

2009 онд хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй уялдуулан иргэдийн орлогын эх үүсвэрийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ажлын байрны өсөлтийг тогтвортой хангах зорилтын хүрээнд аймгийн хэмжээд 3360 шинэ ажлын байр бий болсноос 1601 нь байнгын, 1759 нь түр ажлын байр байна.

Өрхийн хэрэгцээ, чадавхи, санаачлагыг дэмжиж ядуурлаас гаргах ажлын хүрээнд 294 өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлснээс 133 өрхийн амьдрал дээшилж, түр болон байнгын ажлын байраар хангагдан тогтмол орлоготой боллоо.

Дэд бүтэц, байгаль хамгаалал, экологийн чиглэлээр хөдөлмөр зарцуулалт ихтэй мэргэжил шаардахгүй нийтийг хамарсан ажлын 45 төсөл хэрэгжүүлэн эмзэг бүлгийн 1117 иргэнийг хамруулж

хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 91.6 сая төгрөгийг зарцуулан түр ажлын байраар хангаж орлогын эх үүсвэрийг тодорхой хувиар нэмэгдүүлээ.

Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн 17 мэргэжлээр ЕБС төгссөн болон цэргээс халагдсан ажил сургуульгүй залуучууд, хөдөлмөр эрхлээгүй 541 иргэнийг 23 удаагийн сургалтанд хамруулж, 54.0 сая төгрөг зарцуулан, 336 хүн олж авсан мэргэжлийн дагуу ажлын байртай болж хувиараа хөдөлмөр эрхэлдэг боллоо.

Хувиараа аж ахуй эрхлэхийг хүссэн иргэн, аж ахуйн нэгжид шинэ ажлын байр бий болгох нөхцөлтэй, хөнгөлттэй 250.9 сая төгрөгийн богино хугацаатай жижиг зээлийг арилжааны банкуудаар дамжуулан 318 иргэн, аж ахуйн нэгжид олгож, 431 ажлын байр гарснаас 86% нь байнгын үйл ажиллагаа явуулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн дагуу ажилгүй, нийгмийн эмзэг бүлгийн 65 иргэнийг ажилд авч тогтвортой ажиллуулж байгаа 35 ажил олгогчид 23.7 сая төгрөгний урамшуулал олголоо.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг аймагт хэрэгжүүлж Жаргалан, Эрдэнэ, Халиун сумын 15 өрхөд 30.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээр бүлэг хоршоо байгуулах, аж ахуй эрхлэх зэргээр амьжиргаагаа дээшлүүлж өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд зарцууллаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байраар хангах, өрхийн орлогыг нь нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж 8 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын ажлын байраар, мэргэжил, мэргэшил шаардахгүй нийтийг хамарсан ажилд 30 иргэнийг түр ажлын байраар хангаж, зөвлөгөө өгөх мэдээ мэдээллээр хангах үйлчилгээнд 35 хүн, бүлгээр ажиллах чадвар олгох сургалтанд 24 хүн, мэргэжил олгох сургалтанд 34 хүнийг тус тус хамруулж мэргэжлийн үнэмлэх сертификатыг олголоо.

Хүн амын хөгжлийг дэмжих чиглэлээр улсын төсвийн санд тайлант онд нийт 2200256.8 мянган төгрөг төвлөрч 2019951.3 мянган төгрөгийг зарцуулснаас хүүхдийн мөнгөн тэтгэмжинд 11776 өрхийн 22219 хүүхдэд 791567.8 мянган төгрөг, шинээр гэр бүл болсон 763 өрхийн 1526 иргэнд 381500.0 мянган төгрөг, шинээр төрсөн 1480 өрхийн 1490 хүүхдийн тусламжинд 149000.0 мянган төгрөг, Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй 1832 эхэд 343168.5 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмж олгож, Алдарт эхийн 1-р одонтой 1035 эхэд 103500.0, 2-р одонтой 2367 эхэд 118350.0 мянган төгрөг, алдар цолтой ахмад настны хөнгөлөлт, тусламжинд 29 иргэнд 133830.0 мянган төгрөг тус тус эзэлж байна.

2009 онд аймгийн хэмжээнд 18 сум 2 тосгонд “Халамжийн үйлчилгээний менежер” программыг бүрэн нэвтрүүлж, бүх сумдад нийт 32.0 мян.ам долларын үнэ бүхий Notebook, принтерийг олгож, сум бүрт программ ашиглалт жигдэрч, халамжийн үйлчилгээг иргэдэд хөнгөн, шуурхай, давхардалгүй олгох нөхцөл бүрдлээ.

Татварын албанд бүртгэлтэй ажил олгогч нарыг нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгэх ажлыг эрчимтэй зохион байгуулснаар албан ёсоор ажилтан авч ажиллуулдаг шимтгэл төлөгчөөр 358 аж ахуйн нэгж бүртгэгдсэн нь татварын албанд бүртгэлтэй ААН-н 87% болж өмнөх оноос 17%-иар өссөн байна.

Сайн дурын даатгалд 879 иргэн хамрагдахаар гэрээ байгуулсан боловч 559 иргэн хураамжаа төлж даатгалд хамрагдаад байна.

Эрүүл мэндийн даатгалд 45900 хүн хамрагдсанаас 35932 иргэн хураамжаа төлж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах боломжтой боллоо. Даатгуулагчдын өдрийг тохиолдуулан иргэдэд хандсан

сарын аяныг зохион байгуулж 12000 гаруй хүнд сурталчилгаа хийж, “Бодлогын баримт бичиг” хэвлэмэл ном гаргаж, ажил олгогч байцаагч нарт тараалаа.

“Хууль эрх зүйн болон хөдөлмөр эрхлэхтэй холбоотой анхан шатны мэдээллээр хангах” сэдэвт сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж 80 гаруй хүн оролцлоо.

Хүн ам зүй, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, ТББ-ын чиглэлийн мэдээ, мэдээлэл, зөвлөгөө багтаасан “Мэдээлэл” сэтгүүлийг гаргаж 100 гаруй хүнд тарааж сурталчиллаа.

Нийгмийн эмзэг бүлгийн иргэд маань мэдээллийг яаж, ямар замаар олж авдаг, ер нь мэдээллийн хүртээмжийг тодорхойлох, ажил хөдөлмөр эрхлэхэд учирч буй бэрхшээлийг тодорхойлох зорилгоор түүврийн аргаар 100 хүнээс судалгаа авч дүгнэлт гаргалаа.

“Орон нутгийн засаглалыг дэмжих хөтөлбөр” төсөл болон “Тогтвортой амжиргаа төсөл” хөтөлбөрт хандаж, багийн Иргэдийн нийтийн хурал, сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүүхдийн ордны үйл ажиллагааг дэмжүүлсэн санал гарч төсөл хэрэгжүүлэн ажиллаж байна. “Орон нутгийн засаглалыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд “Хүүхдийн ордон”-ы гадна тохижилтын зарим ажлыг 5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ. Энэ ажлыг гүйцэтгэх ажилчдыг Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажил хайж байгаа хүмүүсээс 25 хүнийг 10 өдрийн хугацаатай ажиллуулан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-аас 1.5 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлэн 100м хайс, цэцгийн мандал, усан оргилуур, гэрэлт мандал зэрэг ажлыг гүйцэтгүүллээ.

Хүүхдийн хөгжил авъяас чадварыг хөгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийт 2750000 төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн 30 ширээ, 30 сандал, 10 ширхэг лимбэ, самбар, 2 нум сум, шагайн харвааны иж бүрдэл зэрэг сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгээд байна. Мөн урлагийн чиглэлийн сургалт дугуйлангууд хичээллэх танхимыг тохижууллаа. Хүүхдийн авъяас чадварыг хөгжүүлэх зорилгоор 8 төрлийн дугуйлан /дуу, бүжиг, үндэсний сурын харваа, шагайн харваа, уран зураг, уран зохиолч сэтгүүлч, зураасан зураг, баримал сийлбэр/ хичээллүүлж нийт 274 хүүхэд хамрагдан суралцаж байна.

Хүнд нөхцөлд амьдарч байгаа болон эмчилгээ оношилгоо шаардлагатай, эмзэг бүлгийн нийт 94 хүүхдэд хичээлийн хэрэглэл, хувцас мөнгөн тусламж нийт 750.000 төгрөгний тусламж үзүүллээ.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан хөгжлийн бэрхшээлтэй болон хүнд нөхцөлд амьдарч байгаа 14 хүүхдэд гарын бэлэг, хувцас олголоо.

Томуугийн цартахал, халдварт өвчлөлөөс эмзэг бүлгийн хүүхдүүдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, биеийнх нь дархлааг сайжруулах зорилгоор “Томуугийн эсрэг багц” ийг 100 хүүхдэд хүргэлээ.

#### **Боловсролын талаар:**

2009-2010 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын 28 цэцэрлэгийн 117 бүлэгт 3683 хүүхэд сурч хүмүүжиж, хамран сургалт аймгийн төвд 90.9 хувь, хөдөө орон нутагт 70.8 хувьтай байна. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн багш нарын дунд нэгж хичээлийн болон сэдвийн боловсруулалтын уралдаан зохион байгуулж дүгнэх, багш нарт заах арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт явуулах, сургалт хүмүүжлийн ажлын үр дүнг шалгаж үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөн туслах, хяналт тавих зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

Сургуулийн өмнөх боловсролын 117 бүлэгт мэргэжлийн 75 багш ажиллаж одоогийн байдлаар багшийн хангалт 90.3 хувьтай байна.

Ерөнхий боловсролын 28 сургуульд өдрийн ангийн 467 бүлэгт 12686, эчнээгийн 4 бүлэгт 101, дүйцсэн хөтөлбөрөөр 600 нийт 13387 хүүхэд суралцаж, хамран сургалт 99%-тай байна.

Бага ангийн сурлагын чанар 69.5, амжилт 99.4, дунд ангийн сурлагын чанар 52.9, амжилт 99.2, ахлах ангийн сурлагын чанар 62.7, амжилт 83.3 хувьтай шалгагдсан. Стандарт хангалтын хувь 91.35.

Аймгийн хэмжээнд 650 үндсэн багш ажиллаж байгаагийн 263 нь бага ангийн багш байна. Багшийн хангалт 98.5 хувьтай. Нийт багш нарын 80 орчим хувийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулав.

Сургуулийн дотуур байрны хүчин чадал 2185 хүүхэд хүлээж авах боломжтой. Аймгийн хэмжээнд 2009-2010 оны хичээлийн жилд дотуур байранд суух хүсэлт гаргасан 2419 хүүхдийн 2179 нь малчдын хүүхэд байна. 2269 хүүхэд дотуур байранд амьдарч байгаагийн 2007 нь малчдын хүүхэд байна. Хамрагдалт 92.1 хувь. Дотуур байрны орны тоо Дарив сумд 50, Цогт сумд 75-аар нэмэгдсэн.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвөөс Оёдол эсгүүр, Барилгын өргөн мэргэжил, Барилгын сантехник, гагнуурчин, Хоол үйлдвэрлэл, Мужаан, Худалдааны үндсэн ажилтан, Агрофермер, Хөдөө аж ахуйн фермер, Үсчин гоо засал, Дархан зэрэг 10 мэргэжлээр 177 хүнийг төгсгөсөн. Одоогоор нийт төгсөгчдийн 60-аад хувь нь ажлын байраар хангагдсан. Энэ хичээлийн жилд авто машины засварчины захиалгат анги нээн 31 хүүхэд суралцаж байна.

#### **Соёл, урлагийн талаар:**

Сумдын соёлын төвүүд улиралд 1-2 удаа соёл урлагийн явуулын иж бүрэн үйлчилгээг малчдад хүргэж, соёлын арга хэмжээнд малчдын 70 гаруй хувь хамрагдлаа.

Орон нутгийг судлах музей 2009 онд 3319 үзэгчдэд үйлчилж үзэгчдийн тоо өмнөх оноос 10 хувиар өссөн. Аймгийн соёл урлагийн ажилтны анхдугаар зөвлөгөөний үеэр ард иргэдийн гар дээр хадгалагдаж буй үнэт, ховор эдлэлийн үзэсгэлэн зохион байгуулагдаж 17 сумын 400 гаруй үзмэр үзүүллэг дэлгэгдэж эдгээрээс 5 төрөлд 15 шилдэг үзмэрийг шалгаруулсан.

Аймгийн Нийтийн номын сангийн "Мэдээллийн эринд-залуус бид" төслийг "Тогтвортой амжиргаа 2" төслөөс дэмжин хэрэгжүүлэхээр боллоо. Цахим, интернэт номын сан ашиглалтад орсноор унших номоо цахим катологийн тусламжтайгаар богино хугацаанд хайж олох, зарим ном зохиолыг цахим хэлбэрээр унших, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ярьдаг номоор үйлчлэх, өдөр тутмын сонингуудыг цахим хэлбэрээр унших боломж бүрдэнэ. Электрон хэлбэрт номоо байрлуулах бар код нааж уншлага үйлчилгээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах зорилгоор фондны номны катологийн 50 гаруй хувийг электрон хэлбэрт оруулаад байна.

Мэргэжлийн урлагийн байгууллагууд болон хөдөөгийн соёлын төвүүд ардын авьяастнуудын ур чадварыг дээшлүүлэх, тэднийг дэмжин дэлгэрүүлэх зорилтын хүрээнд 2008-2009 онд нийт 42 уран бүтээлийн тоглолт, цэнгүүнийг зохион байгуулж уг арга хэмжээнүүдэд давхардсан тоогоор 40 гаруй мянган хүн хамрагдсан. Хөдөөгийн соёлын төвүүд дээр түшиглэн ардын уламжлалт урлагийг өвлүүлэх, шавь сургалтыг зохион байгуулж байгаа бөгөөд Тонхил, Төгрөг, Баян-уул, Эрдэнэ, Бугат, Гуулин сумдын соёлын төвүүд санаачлагатай ажиллалаа. АДБ-ийн Алтай чуулга дээр бүжгийн дугуйланд 30 хүүхэд, найрал дууны дугуйланд 50 хүүхэд, Хүүхдийн төлөө хэлтэс дээр бүжгийн дугуйлангийн 120, найрал дууны дугуйлангийн 30 хүүхэд, "Хантайшир -эрдэм цогцолбор" сургууль дээр найрал дууны 30 хүүхэд нийт 260 хүүхэд хичээллэж байна.

#### **Эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортын талаар:**

Эхийн эндэгдэл 100 мянган амьд төрөлтөнд 85,98 болж урьд онд эндэгдэл гараагүй, улсын дунджаас өндөр байна. Нялхсын эндэгдэл 1000 амьд төрсөн хүүхдэд 27,5 промилл болж урьд оноос 0,5 промиллоор буурсан байна. 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрсөн хүүхдэд 37,0 промилл болж урьд оныхоос 1,1 промиллоор нэмэгдсэн байна.

Нийт цочмог халдварт өвчин 11 төрлийн 392 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 70,8 пункт болж урьд оныхоос 484 тохиолдол буюу 80,7 пунктээр буурсан. Ялангуяа халдварт гепатит 107 тохиолдол бүртгэгдэж 10,000 хүн амд 19,3 пункт болж урьд оны мөн үеэс 195 тохиолдол буюу 32,9 пунктээр буурсан байна

Хөнгөвчлөх эмчилгээний аргыг гадаадын мэргэжилтний тусламжтайгаар өрхийн эмнэлгүүдэд нэвтрүүлэхээр үйл ажиллагаа нь эхлээд байна

17 сумын эмнэлэгт Эрүүл мэндийн хөгжил хөтөлбөр төслийн хүрээнд Горевийн тор, гемометри сали, электрон жин, автомат пипетки, хоёр нүдний микроскопи центрфуг, хатаагч шүүгээ гэх мэт лабораторийн багажаар хангасан. Хөхморьт, Халиун, Тайшир, Дэлгэр, Гуулин, Алтай сумаас бусад сумууд лаборатори нь хэвийн ажиллаж байна. НҮБ-ын Хүн амын сангийн шугамаар Алтай сумын хүн эмнэлэгт хурдавчилсан оношлуур олгогдсон. Мөн ДОХ, Тэмбүү өвчнийг илрүүлэх хурдавчилсан оношлуурыг бүх сумд хаваарилаж хүргэсэн

Аймгийн төвийн өрхийн эмнэлгийн бүх эмч ажиллагсад, Нэгдсэн эмнэлгийн халдварт, хүлээн авах тасгийн эмч ажиллагсад нийт 70 хүнд 1.0 сая төгрөгийн өртөг бүхий гахайн ханиаднаас сэргийлэх иж бүрдэл олголоо.

**Хүн бүр өдөрт нэг аяга сүү”** компани ажлын хүрээнд аймгийн хэмжээнд сүүний ач холбогдлыг олон нийтэд таниулах, сурталчлах, эрүүл хооллолтын зөвлөгөө өгөх олон талт ажлуудыг зохиож, аймгийн ТҮ, Радиогоор сурталчилгаа явуулж, телевизээр хэлэлцүүлэг зохион байгуулав.

**НҮБ-ийн ХАС-ын НҮЭМ-ийн хөтөлбөр.** НҮБ-ын Хүн амын сангийн “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөрөөр 2 загвар сумын удирдлагуудын дунд НҮЭМ-ийн мэдээлэл, сургалт, “Үе тэнгийн сургагч” сургалтаар бүх сумдаас 36 сурагч оролцуулан зохион байгууллаа. 2009 оны 1-2-р улиралд: Бигэр сумын хүн эмнэлэгт 35,8 сая төг, Алтай сумын хүн эмнэлэгт 37,0 сая төгрөгийн багаж төхөөрөмж тус бүр олгогдоод байна. Бигэр сумын 12-н жилийн сургууль, Алтай сумын 9-н жилийн сургууль, Есөнбулаг сумын 12-н жилийн 1-р сургуулиудын дотуур байранд нийт 8,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Эрүүл мэндийн өргөө” байгуулагдсан.

#### **Эрүүл мэндийн салбарын хөгжил-3 төсөл:**

ЭМСХХ-3 төслийн аймгийн хяналтын хороо аймгийн засаг даргын захирамжаар байгуулагдаж энэ хугацаанд 2 удаа хуралдаж тухайн үеийн асуудлыг хэлэлцлээ.

Тус аймагт хийгдэх хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийн талаар нийт сумдын удирдлага, эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага, эмч мэргэжилтнүүдэд мэдээлэл хийлээ.

Нэгдсэн эмнэлэг, Шарга, Төгрөг сумын эмнэлгийн барилгын их засварын болон Эрдэнэ, Хөхморьт сумын эмнэлгийн шинэ барилгын зураг төслийн тендер зарлагдах, шалгарсан компаниуд орон нутагт ажиллаж зургийн ажлыг хийж дуусгаад, Барилгын тендерийн асуудал шийдвэрлэх шатандаа явж байна.

Тус аймгийн 10 сумын эмнэлгийн цэвэр усны асуудлыг шийдвэрлэх ажлын тендер зарлагдан үйл ажиллагаагаа явуулахад бэлэн болоод байна. /Жаргалан, БаянУул, Хөхморьт, Шарга, Тонхил, Дарив, Бугат, Алтай, Чандмана, Эрдэнэ /

Аковесийн Монгол дахь албан ёсны төлөөлөгчийн газарт хамтран “Шинэ эмийн мэдээлэл” сэдвээр сургалт зохион байгуулж эмийн аюулгүй байдал, шинэ эмийн талаарх мэдээллийг төгсөлтийн курсын оюутнууд болон эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд хүргэсэн.

Мөн гамшгийн болон томуугийн А хүрээний H1N1 вирусын халдварын үеийн бэлэн байдлыг хангах зорилгоор эмийн хэрэгцээг тооцож эм ханган нийлүүлэх болон эмийн сангуудын удирдлагуудтай уулзан эмийн хангалт нөөц бүрдүүлэх үүрэг өгч ажиллаа.

Алтай, Бигэр, Цогт, Цээл, Халиун сумдаар эмийн чанар, аюулгүй байдал, цус, цусан бүтээгдэхүүний сэлбэлт, бэлэн болон аюулгүй байдалд хяналт үнэлгээ хийсэн.

Сумаас мансууруулах, сэтгэц нөлөөт эмийн тайланг улирал бүр авч хянаж байна.

2009 онд Алтай-2, Дэлгэр-1, Баян-Уул-1, Бигэр-3, Дарив-2, Цээл-1, Чнадмана-1, Шарга-1, Төгрөг-1 сумын эмнэлгүүдэд нийт 13, Марал-Алтай өрхийн эмнэлэгт -2, Жаргалан-Алтай өрхийн эмнэлэгт-2, аймгийн нэгдсэн эмнэлэгт-5 их эмчийг тус тус хуваарилан ажиллуулж байна.

Манай аймгийн төрийн болон хувийн хэвшлийн эмийн сангуудад нийт-41 эм найруулагч, жор баригч нар ажиллаж байна. Үүнээс нэгдсэн эмнэлэгт-4, сумуудад-19, эм инпекс-4, ажлын гэрэлд-4, Алтай тан-4, Алтан гишүүнэ-2, Амин дэм-2, их-зэл-1, Моносын салбарт-1 эм найруулагч, жор баригч нар ажиллаж байна.

Уламжлалт анагаах ухааны төвийн барилгын ажлыг “Уран охид” ХХК гүйцэтгэж байгаа ба аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2009 оны 10-р сарын 30-ны өдрийн 99 тоот албан шаардлагын дагуу 2010 оны 4 сар хүртэл барилга угсралтын ажил түр зогсоод байна.

Алтай сумын хүн эмнэлгийг хүүхдийн их эмч, ерөнхий мэргэжлийн их эмчээр тус тус хангаж, эх баригч бага эмчийг мэргэжил дээшлүүлэн ажиллуулж байна.

Бигэр сумын сум дундын эмнэлэгт 2009 онд мэс засал, НАС-2, ерөнхий мэргэжил-1 нийт 4 эмчийг ажиллуулж байна.

2009 онд дээрх эмнэлгүүдэд НҮБ-ын ХАС-аас 37 сая төгрөгийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл олгоод байна.

Мөн загвар эмнэлэг болох үйл ажиллагааны төлөвлөгөөг төсөл байдлаар хийн Ховд аймаг дахь НҮБХАС-ийн суурин төлөөлөгчийн газарт хүргүүлээд байна.

“ЭМССХХ-3”-ын хүрээнд 2010 онд Эрдэнэ, Хөхморьт сумдын эмнэлгийн барилгыг шинээр барих, Төгрөг, Шарга сумын эмнэлгийн барилгад их засвар хийгдэхээр шийдвэрлэгдсэн.

2009 онд Жаргалан сумын эхчүүдийн амрах байрны эх засварын ажлыг “Алтайн-Өргөө” ХХК 15 сая төгрөгөөр хийж улсын комисс хүлээн авсан.

Нэгдсэн эмнэлгийн барилгын засварын тендерт “Айргын хад” ХХК, “Арвинбэлт” ХХК-ууд шалгаран засварын ажлаа хийж байна.

2009 онд Нэгдсэн эмнэлэгт-3, Дэлгэр-1, Тонхил-1, Халиун-1, Хөхморьт-1, Цээл-1 нийт 8 түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийгдсэн.

Баян-Уул, Бигэр, Дэлгэр, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цогт, Шарга, Чандман сумдын нийт 18 багийн эмчийг мотоциклиор хангахаар захилга хүсэлтийг уламжилж, амьжиргааны чадавхийг дэмжих төсөл хөтөлбөрийн дагуу эхний ээлжинд 8 багийн бага эмчийг унаажуулахаар шийдвэрлээд байна.

Хүн амын дунд нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн арга хэмжээний зохистой хэлбэрийг сонгон, хөдөлгөөний хомсдлоос сэргийлэх ажлыг олон нийтийг өргөнөөр оролцуулан үр дүнтэй зохион байгуулах зорилгоор аймгийн Засаг даргын 2009 оны 02 сарын 06-ны 25 дугаар захирамж гарч ажлын

хэсэг байгуулагдан 10 заалт бүхий төлөвлөгөө батлан ажиллаж байна. Аймгийн хэмжээгээр 10 гаруй байгууллага чийрэгжүүлэх танхим ажиллуулж байна. Чийрэгжүүлэлтийн танхимыг 3 сум, 2 эмнэлэг шинээр байгууллаа. Хүн амын дунд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэндээ хамгаалах зорилгоор бодибилдинг, фитнесийн танхим байгуулж, 20 гаруй хүн хамрагдаад байна.

#### **Биеийн тамир, спортын чиглэлээр:**

Нийтийн биеийн тамир, спортыг аймагт хөгжүүлэх талаар Аймгийн Засаг даргын захирамж гарч 30 хүний бүрэлдэхүүнтэй комисс байгуулагдан ажлын төлөвлөгөө батлан ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу спортын 16 арга хэмжээ зохион байгуулж нийт 20508 хүн хамрагдсан. Мөн бүх сумдад нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх, биеийн тамирын дасгал хөдөлгөөнөөр хүн амыг идэвхтэй хичээллүүлэх боломж нөхцлөөр ханган ажиллахыг уриалга болгосон зөвлөмж хүргүүлээ.

Биеийн тамир спортын барилгын их засварыг 2009.09.25-ний өдрөөс эхлэн RSP компани тендерээр шалгаран гүйцэтгэсэн. Нийт 78 сая төгрөгөөр цахилгааны монтаж, шал, цонх солих, сантехникийн их засварын ажил хийгдэж дууслаа.

Аймагт үндэсний болон чөлөөт бөх, сумо, самбо, жүдо бөх, волейбол, сагсан бөмбөг, хөнгөн, таеквондо, шатар, даам, шагайн харвааны дугуйлан хичээллэж нийт 800 гаруй хүн хамрагдаж байна. Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 1966, улсын аварга шалгаруулах тэмцээнд 89, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд 47 тамирчин тус тус хамрагдсан байна. Нийт 6 төрөлд 12 алт 6 мөнгө, 10 хүрэл медаль, 4 төрөлд тусгай байрт шалгарлаа. 2009 онд шатрын спортын дэд мастер 2, морин спортын мастер 3, таеквондогийн спортын мастер 3, улсын манлай харваач 1 төрөн гарлаа.

#### **Үйлдвэрлэл бизнесийг хөгжүүлэх талаар:**

Монгол улсын Засгийн газраас 2009 оныг “Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил” аймгийн ИТХ-аас мөн оныг “Өрхийн үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрийг дэмжих жил” болгон зарласан.

Энэ ажлын хүрээнд жилийн ажлыг зохион байгуулах хороо байгуулан, төлөвлөгөө гаргаж, жилийн ажлын нээлтийг аймаг, сумдад хийж, бизнес эрхлэгчид, төрийн байгууллага, төрийн бус байгууллагуудад хандсан уриалгыг хүргүүлэн ажиллав.

Аймгийн ИТХ-аар “Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих аймгийн хөтөлбөр”-ийг хэлэлцүүлж батлууллаа.

Жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх санд нийт 840.0 сая төгрөгийг байршуулан, арилжааны банкаар дамжуулан зээл олгох ажлыг зохион байгууллаа.

Төсөл сонгон шалгаруулах дэд комисс ЖДҮ-г дэмжих сангаас зээл авч үйлдвэрээ өргөтгөх, шинэ чиглэлээр үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх зорилгоор төсөл боловсруулсан 239 иргэн, ААН-ийн бизнес төлөвлөгөөнд шалгаруулалт хийж, шаардлага хангасан 126 төслийг банкинд хүргүүлсэн ба банк 95 иргэн, ААН-д 836.5 сая төгрөгийг буюу төлөвлөсөн хөрөнгийн 99.5 хувийг олголоо.

Хүнсний чиглэлээр 29 төсөлд 166.0 сая төгрөгийн, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр 24 төсөлд 148.9 сая төгрөгийн, хөдөө аж ахуйн чиглэлээр 20 төсөлд 270.7 сая төгрөгийн, эм био бэлдмэлийн чиглэлээр 1 төсөлд 140.0 мянган төгрөгийн, барилга, барилгын материалын чиглэлээр 5 төсөлд 100.7 сая төгрөгийн, үйлчилгээний чиглэлээр 15 төсөлд 149.9 сая төгрөгийг олгосон байна.

Төслийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж байгаа ба төслүүд амжилттай хэрэгжсэнээр аймагт 35 үйлдвэр шинээр, 59 үйлдвэр үйл ажиллагаагаа өргөтгөн, зах зээлд шинээр 34 нэр төрлийн бүтээгдэхүүн гаргахаар үйлдвэрлэл эрхлэгчид зорьж ажиллаж байна.

Үйлдвэржүүлэлтийн жилийн хүрээнд төвлөрөх хөрөнгө оройтож байршсан, харилцагч банкны шалгуур болон бусад хүчин зүйлээс шалтгаалан зээлийн олголтын явц эхэндээ удаашралтай байсан боловч төсөл сонгон шалгаруулалтыг эрчимжүүлэн, төвлөрсөн хөрөнгийг буцаан татуулалгүйгээр зохион байгуулснаар жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид шинээр 274 ажлын байрыг бий болгохоор төлөвлөн ажиллаж байна.

Үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах борлуулалтын сүлжээг өргөтгөх зорилгоор сум, аймаг, бүс улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа үзэсгэлэн худалдаануудад үйлдвэрлэгчдийг өргөнөөр оролцуулж байна. Тухайлбал 8-р сард Ховд аймагт зохион байгуулагдсан “Баруун бүсийн түншлэл үзэсгэлэн” худалдаанд 28 аж ахуй нэгжийн төлөөлөл 21 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 15.8 сая төгрөгийн борлуулалт хийж, баруун бүсийн шилдэгийн шилдэг ААН-ээр тус аймгийн үйлдвэрлэл үйлчилгээний “Ентүм” ХХК, шилдэгийн шилдэг бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл үйлчилгээний “Тулга-Алтай” ХХК-ийн овьёостой гурилан бүтээгдэхүүн шалгарсанаас гадна барилга, модон эдлэлийн төрлөөр алтан медаль, бусад чиглэлийн үйлдвэрийн бүтээгдэхүүнээр 5 хүрэл медаль авлаа.

“Алтай түншлэл үзэсгэлэн-2009” худалдааг 9-р сард зохион байгуулж, нийт сумд болон Баянхонгор, Ховд аймгийн төлөөлөл 139 үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг иргэн, ААН-үүд 20 төрлийн 139.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн ажил үйлчилгээгээр оролцож, 80.6 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Энэ онд шалгаруулах номинацийн хэмжээ өмнөх оноос 3-аар нэмэгдэж, нийт 23 багц буюу 69 медалийн төлөө бизнес эрхлэгчид өрсөлдлөө.

Улаанбаатар хотод зохиогдсон “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаанд “Газрын өгөөж” хуримт хоршоо, “Говийн ургац” нөхөрлөлүүдийг оролцуулж, газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын үйл ажиллагааг сурталчилж, бүтээгдэхүүнийг борлуулах зээлээ олоход нь туслаж ажиллав. Уг үзэсгэлэн худалдаагаар 10 гаруй сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Үйлдвэржүүлэлтийг дэмжих жилийн хүрээнд бизнесийнхний зөвлөгөөнийг зохион байгуулсанаас гадна сургалтын байгууллагууд 500 гаруй иргэнд бизнесийн сургалт зохион байгуулж, зөвлөгөө мэдээллээр хангалаа.

#### **Мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар:**

“Мал аж ахуйн үйлдвэрлэл-хамтын хөдөлмөр” сэдэвт малчдын аймгийн зөвлөгөөнийг 2009 оны 2 сард зохион байгуулсан ба зөвлөгөөнд 250 гаруй малчин, хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд болон аймаг, сумдын удирдлагууд оролцов.

Зөвлөгөөний үеэр Дарив сумын “Буян-Ундрал” Улсын тэргүүний хоршооны туршлагаас танилцуулж, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг хоршоо, фермер байгуулж ажиллах нь ямар давуу талтайг сурталчлан, зөвлөгөөнөөс гарсан төр засагт сонордуулах бичгийг холбогдох газруудад хүргүүлэн ажиллав.

Мөн сумдын тэргүүний хоршоонуудын арга туршлага судлах үзүүлэх сургалт зохион байгуулж, ЖДҮГ-аас хоршооны талаар хийж байгаа СНФ байгууллагын судалгаанд хөдөө аж ахуйн 19 хоршоог

хамруулаад байна. “Хужирт Жавхлан” хоршоо ХАА-н хоршоологчдын холбооны тэргүүний хоршоо шалгаруулах болзолд 2 дахь удаагаа шалгарлаа.

Мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд эрчимжсэн аж ахуй байгуулах аж ахуйн нэгжүүдэд ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас 102 сая төгрөгийн зээлийг олгуулсанаас “Ус Харуул-Алтай” сүүний чиглэлийн 14 үхэртэй, “Хонгор буурал” ХХК, Дэлгэр сумын “Сор манлай нөхөрлөл”-үүд тус бүр 10 саалийн үнээтэй фермерийн аж ахуй, Цөм сүргийн үржлийн төв ТӨҮҮГ 125 тулман хөхт ямаа авч, 1000 өндөглөгчийн дулаан байр барих ажлыг эхлүүлээд байна.

Аймаг мал сүргээ 97 хувиар онд оруулж, 691.1 мянган төл 86.1 хувиар бойжуулж, өмнөх оноос малын тоо толгой буурч, 2171.8 мянгад хүрлээ. Төгрөг сум малаа дүнгээр нь болон 4 төрөл дээр нь, Дарив, Тонхил сумд малаа 2 төрөл дээр нь, Бигэр, Дэлгэр, Жаргалан, Шарга, Есөнбулаг сумд тус бүр малаа 1 төрөл дээр нь өсгөж, бусад сумууд малаа 5 төрөл дээр нь буулгалаа. Энэ онд малжуулалтанд 317 өрхийг хамруулж, 12.5 мянган толгой малтай болгоход төсөл, хөтөлбөрөөс 333.9 сая төгрөгийг зарцуулав.

“Малын чанар сайжруулах” хөтөлбөрийг хэрэгжүүлэн нэгжээс ашиглах ямааны ноолуур, тэмээ, хонины ноосыг аймгийн дүнгээр нэг малаас 10-15 гр-аар нэмэгдүүлэхэд чиглэсэн селекцийн ажил явуулж тэмээ, хонь, ямаан сүрэг дэх тохиромжтой хэвшлийн малын тоог 350 мянган толгойд хүргэж, өмнөх оныхоос 8.4 хувиар өсгөлөө.

Малын үзлэг ангилалт, хээлтүүлэгч малын аттестатчилалыг Цээл, Бугат, Тонхил, Дарив, Дэлгэр зэрэг сумдад зохион байгуулж, 102.1 мянган малд үзлэг ангилалт хийж, хээлтүүлэгчийг хянан баталгаажууллаа.

Аймгийн хэмжээнд 2122.8 мян.толгой малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд, 2266.6 мянган малыг паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулж, 302.6мян.м<sup>2</sup> талбай бүхий хашаа хороо, агуулах, зоорийг ариутгаж, халдваргүйжүүлэх арга хэмжээ авч, 2000 адуунд ям, 1000 үхэрт сүрьеэ өвчний, 3000 дээжинд сүүний цагираган урвалын шинжилгээ 14.0 мянган толгой малд бруцеллээс өвчний шинжилгээ хийлээ.

Энэ онд аймгийн хэмжээгээр 513,6 тн мах, махан бүтээгдэхүүн, 55.4 тн сүү, сүүн бүтээгдэхүүн, 198 тн ноос, ноолуур, 32057 мянган ширхэг арьс, ширэнд тус тус мал эмнэлэг ариун цэврийн үзлэг, шинжилгээ хийж, 302,6 мянган метр квадрат хашаа, хороо, зоорь, агуулах, малын байранд халдваргүйжүүлэлт хийлээ.

Хувийн мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжүүдийг аттестатчлалд бэлтгүүлэх, аттестатчлал явуулах ажлын хэсгийг томилон ажиллуулж, 41 МЭҮҮ нэгжид стандартын түвшин тогтоох үзлэг хийснээс 38 нэгж буюу 92.6 хувь нь хамрагдаж, 5 нэгж буюу 29 хувь нь стандартын шаардлага хангаагүй гэсэн дүн авсан байна.

Жаргалан сумын “Гүнэбулаг” мал эмнэлэг үржлийн үйлчилгээний нэгж дээр “Мал эмнэлгийн нэгжийн стандарт түүний хэрэгжилт” сэдэвт үзүүлэх сургуулийг зохион байгуулж, энэ арга хэмжээнд бүх сумдын мал эмнэлгийн үржлийн үйлчилгээний нэгжүүдийн захирал нар болон хүнс хөдөө аж ахуйн мэргэжилтэнүүдийг оролцуулж, туршлага судлуулах ажлыг ХХААЖДҮГ, МХГ-тай хамтран зохион байгуулав.

Аймгийн нийт нутгаар 2008-2009 онд харьцангуй бага хур тунадас орсноос шалтгаалан нийт нутгийн 23.7 хувь нь гандуу, 76.3 хувь нь гантай, бэлчээрийн ургац 0.0-0.2 ц/га байгаа гэсэн дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаас гаргасан юм.

Ус цаг уурын хүрээлэнгээс 2009-2010 оны өвөл, хаврын бэлчээрийн даац, багтаамжийг баг бүрийн бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэл дээр үндэслэн тооцоолж гаргахад аймгийн ихэнх сумдад тухайлбал Баян-Уул, Жаргалан, Тайшир, Шарга, Тонхил, Бугат, Эрдэнэ, Бигэр, Чандмань, Цээл сумын нутагт бэлчээрийн даац 3 дахин хэтэрсэн дүгнэлт гарсан болно.

Өвөлжөө, хаваржааны бүсээс бусад бэлчээрийн даац нь боломжтой нутгийг ашиглан нийт мал сүргийн 86 хувь нь буюу 2.1 сая мал зун, намрын оторт гарсан боловч мал сүргийн 40 хувь нь дундаас доош тарга хүч авсан.

11-р сарын эхнээс эхлэн цас ихээр орж, хүйтний эрч хадгалагдан, цаг агаар хүндэрсэнтэй холбогдуулж, Засгийн газарт удаа дараа хүсэлт тавьсны дагуу орон нутагт ажлын хэсгийг ирүүлэн, нөхцөл байдалд үнэлгээ хийж, 900 тонн өвс, 900 тонн тэжээл, отроор явж буй малчдад үзүүлэх үйлчилгээнд 60.0 сая төгрөг, Төгрөг, Жаргалан сумдын хүн эмнэлгийн түргэн тусламжийн машины асуудлыг шийдүүлж сумдад хүргүүлэх ажлыг зохион байгууллаа.

Малчид өөрсдийн хүч хөрөнгөөр 32 гар худаг гаргаж, бэлчээр усжуулах арга хэмжээ авсны зэрэгцээ улсын төсвийн 310.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 сумд 16 худаг шинээр гаргаж, 80 уст цэг тогтоосон.

Аймгийн аваргад 24, улсын аварга малчин, тариаланч 4, үйлдвэрлэгч 2 хүнийг шалгаруулж, Засаг даргын зөвлөл болон ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд оруулснаас Улсын сайн малчин, тэргүүний тариаланчаар 3, аймгийн сайн малчин, тэргүүний тариаланчаар 24 малчин, тариаланч шалгарлаа.

#### **Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар:**

Газар тариалан эрхлэгчдийн зөвлөгөөн, сургалтыг зохион байгуулж, 134 тариаланч механикжуулагчдыг хамруулав.

Газар тариалан эрхлэгчдэд тус онд 19.7 сая төгрөгийн төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамлын үр, 126.1 сая төгрөгийн 17 бага оврын трактор, 18 хүлэмжийг олгож, дэмжлэг үзүүллээ.

Сумдын Засаг дарга нарт жил бүр тариалах талбай, хураан авах ургацын даалгаврыг өгч биелэлт үр дүнг тооцон ажилласны дүнд тариалах талбайг 218 га-гаар нэмэгдүүллээ.

Ингэснээр өнгөрсөн оноос тариалах талбай 11 хувиар, хураан авсан ургац 12 хувиар тус тус нэмэгдэж, гурилын хэрэгцээний 12 хувь, төмсний 53 хувь, хүнсний ногооны 36 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна.

Бигэр сумын Мянгайн услалтын систем, Цогт сумын Хаяагийн услалтын системийн толгойн барилгын засваруудыг улсын төсвийн 199 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэлээ.

“Атрын 3 дахь аян”-ны хүрээнд Агропарк төсөлийг хэрэгжүүлж төслийн хүрээнд бүх сумдад дуслын усалгааны систем бүхий 120 м<sup>2</sup> хүлэмжийг гэрээгээр нийлүүлэн ХХАХҮЯ-ны ХАА-н үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх төвтэй хамтран “Хүлэмжийн аж ахуй эрхлэх технологи” сэдэвт сургалтыг зохион байгуулж сургалтанд 18 сумын 54 иргэнийг хамрууллаа. Аймгийн хэмжээнд нийт 3330 м<sup>2</sup> талбай бүхий 48 хүлэмжийг ашиглаж 34.5 тн нарийн ногооны ургац хураан авч айл өрх, албан байгууллагын хэрэгцээнд нийлүүллээ.

#### **Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар:**

Сүү, гурил, төмс, хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэхээр аймгийн Засаг даргын бүтээлч албан даалгаврыг гаргаснаас гадна мах хадгалах зоорийн судалгааг гаргаж, аймгийн төвд 300 тн-ын багтаамжтай аммиакан хөргүүртэй махны зоорийг сэргээн ашиглах талаар “Энтүм” ХХК-д 50.0 сая

төгрөгийн, 200 тнын багтаамжтай ногооны зоорийг ашиглуулахаар “Түмэн-Алтай” ХХК- нд 20.0 сая төгрөгийн зээлийг жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас олгуулж мах, ногооны нэгдсэн зоорийг засварлуулах ажлыг хийж эхлүүлээд байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар МХГ, Аймгийн нэгдсэн зах, Дэлхийн Зөн олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, Дэлхийн зөн олон улсын байгууллага хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний 1-р шатны судалгааг Есөнбулаг, Цогт, Баянтооройн иргэдийн дунд явуулж, МХГ-аас “Тулга-Алтай” ХХК-ны 21 ажилтан, аймгийн нэгдсэн зах дээр үйл ажиллагаа явуулдаг гуанзуудын 17 ажилтнууд нийт 38 хүнд “Үйлдвэрлэлийн дамжлага дахь хүнсний эрүүл ахуйн хяналт, үйлдвэрлэлийн зохистой дадлага” сэдвээр сургалт зохион байгууллаа.

“Хүүхэд бүрт өдөрт нэг аяга сүү” аяны хүрээнд сүүний ач холбогдол хангамж, хэрэглээ, тулгамдаж байгаа асуудлын талаар Норвегийн Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний төсөлтэй хамтран нэвтрүүлэг бэлтгэж, орон нутгийн хэвлэл мэдээлийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулав.

Хүн амыг чанартай баталгаатай, хүнс тэжээлээр хангах хүнсний үйлдвэрлэл үйлчилгээ, эрүүл ахуй ариун цэврийн аюулгүй байдлыг хангуулах талаар “Хүнсний баталгаат байдал” дэд хөтөлбөрийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулан хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна.

Чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүний худалдаалалтанд 2008 онд давхардсан тоогоор 10 сум, 662 объектод үзлэг, хяналт хийж байсан бол 2009 онд 17 сум, 1153 объектод үзлэг шалгалт хийж, 39 нэрийн 2190 ширхэг, 203 кг, 395 литр 5.3 сая төгрөгийн чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг актлаж устгасан болно.

#### **Дэд бүтцийн талаар:**

Алтай хотын цахилгаан эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газар, холбогдох яамдад удаа дараа хүсэлт тавьж, 500 кВт-ын 2 ширхэг дизель генераторыг суурилуулснаар 9 дизель ажиллаж, төвийн орон сууц, албан газруудыг 24 цаг, гэр хорооллыг 20-24 цагаар цахилгаан эрчим хүчээр хангаж байна.

Харин Жаргалан, Тайшир сумдын цахилгаан эрчим хүчний хэрэглээг Тайширын УЦС-аас 24 цагаар, бусад сумд дизель станцаар хоногт 2-3 цаг цахилгаан эрчим хүчээр хангагдаж байна.

Аймгийн дулаан хангамжийн тухайд хөдөөгийн 17 сум, 2 тосгоноос Дарив, Тайшир, Эрдэнэ сумдууд төвлөрсөн систем бүхий дулааны уурын зуухтай, бусад 14 сум 2 тосгон нь нам даралтын уурын зуухаар сумын ЗДТГ, хүн эмнэлэг, сургууль, соёлын төв, цэцэрлэгийг дулаанаар хангаж байгаа юм.

Аймгийн төв /Есөнбулаг сум/-д “Мандал-Голомт”, “Ундррам-Оюу”, “Удмын-Ундраа” гэсэн 3 компани 5 хэсэгт байрласан ОХУ болон БНХАУ-д үйлдвэрлэсэн 20,65 мВт-ын хүчин чадалтай 10 зуух ажиллуулж, Алтай хотын 101 албан байгууллага, орон сууцны 900 гаруй айл өрхөд дулаан хангамжийн үйлчилгээ үзүүлж байна.

Алтай хотын дулаан хангамжийн 90 гаруй хувийг дангаараа ханган үйл ажиллагаа явуулдаг “Мандал-Голомт” ХХК нь уурын зуухныхаа хүчин чадлыг 2,5 мВт-р нэмэгдүүлсэн хэдий ч 2-р уурын зууханд суурилагдсан БНХАУ-д үйлдвэрлэсэн 7 мВт-ын хүчин чадалтай уурын зуух нь орон нутгийн онцлогт нийцээгүйгээс шалтгаалан эвдрэл, саатал ихээр гарч, дулаан хангамж ихээхэн доголдож байна.

Орон нутгийн замын сангийн 114.5 сая төгрөгийн санхүүжилтээр Дарив сумын төвийн модон гүүрний засвар, Есөнбулаг сумын Дөтийн давааны 12км хайрган замын засвар болон Жаргалант багт 2.2 км сайжруулсан хайрган зам шинээр барих ажлуудын зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, зураг төсвийг нь бэлэн болгосны хамт Жаргалант багт зорчигч тээврийн үйлчилгээ явуулах зорилгоор 2.2 км сайжруулсан хайрган замыг барьж ашиглалтанд орууллаа. Мөн хотын доторх хатуу хучилттай замд засвар арчлалт хийж, 278 м2 нөхөөсийн ажлыг орон нутгийн тусгай зөвшөөрөл бүхий “ГА-АЗЗА” ХК гүйцэтгэлээ.

Нисэх онгоц хөөрч, буух хатуу хучилттай 2,9 км зурвас хийх ажлаас онгоц түр буух 2.3 км нягтруулсан шороон зурвас, үерийн далан барих ажил дуусч ашиглалтанд орсон бөгөөд 60 см ухмалын ажил, I үеийн 30 см суурийн ажлыг тус тус хийгдлээ.

Есөнбулаг сумын Засаг даргын захирамж гарч, Алтай хотын зорчигч тээврийн үйлчилгээний чадавхи, зохион байгуулалтыг сайжруулснаар Алтай хотын зорчигч тээврийн үйлчилгээнд давхардсан тоогоор 20.8 мянган зорчигч тээвэрлэж, 4 576,0 мянган төгрөгийн орлого олж, төсвөөс 1.8 сая төгрөгийн дэмжлэг авч, 6.5 сая төгрөгийн зардал гаргалаа.

Шуудангийн үйлчилгээний газарт зорчигч, шуудан тээвэрлэх тусгай зөвшөөрлийг олгон цаашид сумдад зорчигч шуудан тээвэрлэхээр бэлтгэл ажил хийгдэж байгаа бөгөөд Тайшир сумд 7 хоногт 2 удаа шуудан хүргэж байна.

Хот хоорондын зорчигч, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээнд нэг шинэ автобус авч шуудан солилцоо 7 хоногт 4 болж нэмэгдсэн.

Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээнд гэрээт аж ахуйн жолооч нар 400.0 сая төгрөгийн парк шинэчлэлт хийж нийт 8 дунд оврын автобус, Истана микроавтобус 15 шинээр үйлчилгээнд орсон нь иргэдийг соёлтой, тав тухтай зорчих нөхцөл боломжийг бүрдүүлсэн арга хэмжээ болсон нь зорчигч тээврийн өсөлтийг 21 хувиар нэмэгдүүлсэн.

Улсын хэмжээнд хэрэгжихээр төлөвлөгдсөн сум орон нутгийг өндөр хурдны шилэн кабелиар интернэт өгөгдлийн сүлжээнд оруулах төслийн хүрээнд Халиун, Цээл, Бугат, Төгрөг, Бигэр, Цогт, Жаргалан Баян-Уул, Хөхморьт, Шарга сумдад шилэн кабелийн угсралт суурилуулалтын хайгуулын ажил хийгдлээ.

DSLAM, ADSL ашиглан шинээр 150 өрхийг интернэтжүүлж, интернэтэд холбогдсон өрхийн тоо 300-д хүрч, Тайшир сум, Дэлгэр сумын Гуулин багийг шилэн кабельд холбоод байна.

Алтай, Бугат, Цээл сумдын болон Баянтоорой багийн төвийн 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах шугам шинэчлэх ажлыг хийж дууслаа. Бугат сумын нарны цахилгаан станцын эх үүсгүүрийн хүчин чадлыг 80 кВт-аар нэмэгдүүлэх ажлыг “Ньюпаур” ХХК, Алтай сум /202,5квт/, Баянтоорой тосгонд /102,6квт/ нарны цахилгаан станц байгуулах ажлыг "Коисиро", "Малчин трейд" ХХК-иуд гүйцэтгэж байна.

УИХ-ын гишүүний тойрогтоо зарцуулах хуваарьт төсвийн 152.8 сая төгрөгийн санхүүжилтээр Есөнбулаг сумын төвийн 6 км гудамжийг, “ТА-II” төслийн 8.0 сая төгрөгийн санхүүжилтээр Харзат багийн гудамжийг гэрэлтүүлэгтэй болгох ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтанд оруулсан.

#### **Барилгын салбарын үйлдвэрлэлийн талаар:**

Алтай хотын инженерийн шугам сүлжээ бүхий бүсэд үйлчилгээний төвийн 4 барилгын угсралтын ажил хийгдсэнээс 2 үйлчилгээний төвийг, амины орон сууцны “Хөгжил” хорооллын

инженерийн шугам сүлжээг орон нутгийн төсвийн санхүүжилтээр өргөтгөн иргэдэд газар олгосноор 11 иргэн хувийн хөрөнгөөр орон сууц барьж ашиглалтанд орууллаа.

Улсын төсвийн 19.9 сая төгрөгийн санхүүжилтээр Есөнбулаг сумын 4-р цэцэрлэгийн цэвэр ус, ариутгах татуургын шугам сүлжээг засварлан төв шугамд холбох бэлтгэл ажлыг гүйцэтгэлээ.

Орон нутгийн төсвийн санхүүжилтээр Алтай хотын ундны усны нөөц нэмэгдүүлэхээр Харзатын районд 120 м гүн худаг шинээр гарган ашиглалтанд орууллаа.

“Шинэ эрин Залуучууд хөгжил төв” ТББ, Франц улсын “АРЕЕД” ТББ хамтран Төгрөг сумын төвийн усан хангамжийг сайжруулах төслийн хүрээнд гүний худаг шинээр гаргаж, 3 ус түгээх байр барьж ашиглалтанд оруулаад байна.

Мөн 2010-2012 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээний талаарх саналыг боловсруулан ЗТБХБЯ-д хүргүүлээ. Алтай хотын төвийн газар доорх инженерийн шугам сүлжээний зураглалыг шинэчлэн гаргах, шинэчлэн засварлах шаардлагатай шугамын хэмжээг гаргаж, зурагт оруулж дуусав.

Ханын материал үйлдвэрлэж байгаа “Аксу-Алтай” тоосгоны үйлдвэр 90.0 сая төгрөгийн 600.0 мян, “Тулга-Алтай” ХХК 2480.0 сая төгрөгийн 1500.0 мян. ширхэг тоосго, “Айргийн хад” ХХК 9.7 сая төгрөгийн 19.5 мян. ширхэг өнгөлгөөний тоосго, 14.4 сая төгрөгийн 62.0 мян. ширхэг явган замын хавтан, 74.4 сая төгрөгийн 12.0 мян. хайрган блок, 2.3 сая төгрөгийн 67 м2 төмөр хайс, 2.4 сая төгрөгийн 700 ширхэг замын хашлага, “Дуурсах-Алтай” ХХК 15.1 сая төгрөгийн 12.6 мян. ширхэг хайрган болон хөнгөн дүүргэгчтэй блок, 1.8 сая төгрөгийн 6.5 м3 төмөр бетон кольцо, 0.7 сая төгрөгийн 87 м2 пластмассан цонх үйлдвэрлэж иргэн, ААНБ-уудын хэрэгцээнд нийлүүлэв.

Эдгээр үйл ажиллагаа явуулж буй тоосгоны, төмөр, бетон эдлэл, блокны үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний чанар стандартын шаардлагыг хангуулахын тулд “Арвин бэлт” ХХК-ийн барилгын материалын лабораторийг өргөтгөн шинэчилж, нэгдсэн лабораторитой болгох зорилгоор “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 6.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр тус компани БНХАУ-аас холбогдох төхөөрөмжүүдийг оруулж ирэхээр гэрээ байгуулж захиалга өгсөн ба бэлтгэл ажлууд хийгдэж эхлээд байна.

Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооноос боловсруулсан “Барилгын материалын үйлдвэрийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд манай аймгийн Тайшир сумын шохойн чулууны ордыг түшиглүүлэн цементийн жижиг үйлдвэр байгуулахаар тусгагдсаны дагуу тус холбоонд “Техник эдийн засгийн үндэслэл боловсруулж өгөхийг хүссэн санал тавьж судалгааны ажил хийгдэж байна.

#### **Байгаль орчин, аялал жуулчлал, газрын шинэтгэлийн тухай:**

“Агаарыг хамгаалах” хөтөлбөрийн хүрээнд БОАЖЯ-тай хамтран тус аймгийн төвд 11.0 сая төгрөгийн өртөг бүхий агаарын чанарыг судлах станцыг байгууллаа. Энэхүү станц нь 2009 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн агаарт байгаа NO, SO-ийн хэмжээг тодорхойлох ажиглалтуудыг хийж, сар бүр ажиглалтын тайлан мэдээг БОБХЗТЛабораторид явуулж байна.

“Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Дэлгэр сумын Гуулин тосгоны “Алтайн дээж” хоршоо 5 га-д, “Жимсгэнэ-Гуулин” хоршоо 5 га-д, нийт 10 га талбайд ойжуулалтын ажил гүйцэтгэснийг “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын дагуу аймгийн Засаг даргын 2009 оны 286 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг намрын тооллогын

ажлыг 10 дугаар сарын 13-аас 15-ны хооронд явуулж, дунджаар 85 хувийн амьдралттайгаар хүлээн авсан байна.

Мөн Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Цогт сумын Баянтоорой тосгонд ГИДЦГ-ын Хамгаалалтын захиргааны ботаникийн цэцэрлэгт 6,6 га, Есөнбулаг сумын “Ногоон байгууламж” төсөл 10 га, Халиун сумын “Намалзахын хишиг ” хоршоо 10 га, Бугат сумын “Цэцэрлэгжүүлэгч” хоршоо 3,4 га, Есөнбулаг сумын 11 жилийн 1-р сургууль 6,6 га, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс 4.3 га талбайд тус тус ойжуулалт хийж гүйцэтгэсний амьдралт 79.6 хувьтай хүлээж авлаа.

Булаг шандын эхийг хашиж, хамгаалах ажлын хүрээнд Бигэр сумын Уртын булаг, Халиун сумын Голын эхний Хойд булаг, Урд булаг, Чандмань сумын Шүрэн булаг, Шарга сумын Харганатын булаг, Цогт сумын Сухайтын булаг, Тайшир сумын Мөрөнгийн ам, Шар булаг, Тонхил сумын Тахилгатын булаг, Есөнбулаг сумын Олон нуур, Дөрөө булаг, Дарив сумын Усны эх булаг, Бугат сумын Майхан толгойн булаг, Төгрөг сумын Тахилгатын булаг, Дэлгэр сумын Хадатын рашаан зэрэг 15 булгийн эхийг хашиж хамгаалсан ажлыг аймгийн Засаг даргын 2009 оны 286 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг шалгаж, сумын Засаг даргын Тамгын газарт актаар хүлээлгэн өглөө.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд даргын баталсан удирдамжийн дагуу аймгийн МХГ, Тагнуулын хэлтэс, БОАЖГазар хамтран 06 дугаар сарын 19-нөөс 21-ний хооронд амралт, сувилал, аялал жуулчлалын баазуудын стандарт, үйлчилгээний чанар, зэрэглэлд хяналт шалгалт хийж, нэгдсэн дүгнэлт гарган цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсрууллаа.

Уг үзлэг шалгалтанд Жаргалан сумын “Хүнхэр зуслан-аялал жуулчлалын цогцолбор”, “Эрээн нуур” амралт-аялал жуулчлалын бааз, Гуулин тосгоны “Хөгжилтэй- Андууд” хүүхдийн зуслан, Есөнбулаг сумын нутаг дэвсгэрт орших “Дуган хад” амралтын газар, “Жуулчин-Алтай” аялал жуулчлалын бааз, аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн дэргэдэх “Ахмадын сувилал” тус тус хамрагдлаа.

Энэхүү хяналт, шалгалтын ажлын нэгдсэн дүнг аймгийн МХГ-ын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн улсын МХЕГ-т дүнг хүргүүлсэн.

Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Аялал жуулчлалын үндэсний төв хамтран 12 сард зохион байгуулсан “Mongolia ITF-2009” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, музей, зочид буудлын, үйлчилгээ эрхлэгчид, гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг оролцууллаа.

#### **Геологи уул уурхайн салбарт:**

Тус аймагт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн уулзалтыг Улаанбаатар хотод зохион байгуулж, орон нутгаас сонгогдсон УИХ-ын гишүүд, орон нутгийн удирдлагууд, мөн лиценз эзэмшигч 60 гаруй компанийн төлөөлөл зэрэг нийт 70 гаруй хүн оролцлоо.

Энэхүү уулзалтаар уул уурхайн салбарт тус аймгаас цаашид баримтлах бодлогын талаар танилцуулж, орон нутгийн төр захиргааны байгууллага, лиценз эзэмшигчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар харилцан санал солилцлоо.

Шинээр олгож буй ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлд аймгийн Засаг даргаас санал авахаар ирүүлсэн 55 өргөдлийн 37 өргөдөлд дэмжсэн, 18 өргөдөлд дэмжээгүй санал өгч хуулийн хугацаанд нь ГУУКХ-т хүргүүлж ажилласан байна.

Аймгийн хэмжээнд энэ оны эцсийн байдлаар ашигт малтмалын хайгуулын 222, ашиглалтын 10 лиценз эзэмшигч байснаас хайгуулын 52, ашиглалтын 4 лиценз эзэмшигч огт үйл ажиллагаа явуулаагүй байсныг холбогдох хууль, тогтоомжийн дагуу лицензийг нь цуцлуулах саналаа ГУУКХ-т хүргүүлсэн.

Үүний зэрэгцээгээр “Хууль бусаар гар аргаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зогсоож, хяналт тавих тухай” аймгийн Засаг даргын 2009 оны 204 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Есөнбулаг сумын Шаврын гол, Рашаант, Ялаат, Наран, Халиун сумын Чацран, Тайшир сумын Мөрөн, Далан, Цогт сумын Аргалийн шанд, Шарга сумын Дунд шарын ам, Сондуулт, Бигэр сумын Сэрхийн нуруу зэрэг газруудад хууль бусаар алт олборлож буй иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээг МХГ, Цагдаагийн хэлтэс, Тагнуулын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс зэрэг хууль хяналтын байгууллагуудтай хамтран 38 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 65000 хүнийг хөөн тарааж мотор, помп 326 ширхэг, металл эрэгч буюу мэдрэгч 49 ширхэгийг хураагаад байна.

Гар аргаар алт олборлосны улмаас эвдрэлд орсон газарт нөхөн сэргээлт хийх ажлын хүрээнд Алтай сумын “Шувуутайн сайрт” 2 га-д Есөнбулаг сумын нутаг Шаврын голд 0.5 га-д, Ялаатад 0.56 га-д, Эрдэнэ сумын Оймын нуруу гэдэг газар 0.8 га-д, Чандмань сумын Самдандамба ууланд 1.5 га –д, Тонхил сумын Шар хоолойд 4.5 га-д, Халиун сумын Чацранд 1.5 га-д нийт 11.36 га-д техникийн нөхөн сэргээлтийг хийлгэлээ.

Аймгийн МХГ, БОАЖГ-тай хамтран ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа газруудад 2009 оны 7 дугаар сарын 01-нээс, 11 дүгээр сарын 01-ний хооронд хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа.

Уг шалгалтанд хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа 6, нүүрс олборлогч 2, төмрийн хүдэр олборлогч 1, тоосгоны үйлдвэрлэл эрхлэгч 3, замын ажил гүйцэтгэгч 1, гар аргаар алт олборлолт явуулж байгаа 4 газрыг хамруулж, шалгалтын дүнг улсын Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлсэн.

Аймгийн нүүрсний хэрэгцээг хангах зорилгоор энэ онд Мааньтын нүүрсний уурхайгаас 15000 тонн, Зээгтийн нүүрсний уурхайгаас 3280 тонн нийтдээ 18280 тонн нүүрс олборлоод байна.

Мөн тус аймгийн Цээл сумын нутагт орших Таяннуурын төмрийн хүдрийн уурхайгаас “Алтайн хүдэр” ХХК энэ онд 41950 тонн хүдрийг олборлож Бургастайн хилийн боомтоор БНХАУ-д экспортлоод байна.

### **Батлан хамгаалах бодлого, гамшгаас хамгаалах тухай.**

#### **Орон нутгийн хамгаалалтын талаар**

Засгийн газраас дэвшүүлж буй “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалах, иргэдийн аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах болон цэргийн шинэчлэлийн бодлогыг үргэлжлүүлэх, бүсчилсэн хөгжлийн бодлоготой нийцсэн орон нутгийн хамгаалалтын удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх “ гэсэн батлан хамгаалах стратегийн зорилгод шууд хувь нэмрээ оруулахад чиглэгдсэн ажиллаа.

Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Батлан хамгаалах салбарын чиглэлээр 4 багц 12 хэрэгжүүлэх асуудлыг тусгаж өгсөн бөгөөд дээрх асуудлуудаас үндэслэн аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд 14 асуудал тусгагдаж биелэлт 97.5%, аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чилэлд 3 асуудал тусгагдсан 100% биелэгдсэн.

Халх голын ялалтын 70 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах тухай Батлан хамгаалахын сайдын тушаал, ажлын төлөвлөгөөг цэргийн штабын даргаар ахлуулсан ажлын хэсгийг томилон 2008 оны 12 дугаар сарын 22-ны өдөр ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөг 15 заалттайгаар аймгийн Засаг дарга бөгөөд Батлан хамгаалах газрын даргаар батлуулан аймаг, сумд албан байгууллагуудын хэмжээнд олон ажлыг зохион байгууллаа.

Халх гол, болон 1945 он, 1948 оны баруун хилийн тулгаралтанд оролцсон ахмад дайчдын судалгааг шинэчлэн гаргагасан бөгөөд эдгээр 17 ахмад дайчдын байгуулсан гавьяа, алба хааж явсан түүхэн замналыг нийтэд сурталчлах, “Алтайн эрин” сантай хамтран ахмад дайчдад хүндэтгэл үзүүлж дурсамж, гарын бэлэг гардуулах ажлыг “Зэвсэгт хүчний-88” жилийн ойг тохиолдуулан зохион байгууллаа.

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 3 дугаар бүлгийн 12 дугаар зүйл, аймгийн Засаг даргын 2009 оны 87, дугаар захирамжаар томилогдсон аймгийн цэрэг татлагын товчоо 2009 оны I, II ээлжийн цэрэг татлагын ажлыг зохион байгууллаа. I ээлжийн цэрэг татлагаар ХЦ-т-110, ЗХ-нд 51, ДЦ-т 25 хүнийг тэнцүүлэн хяналтын тоог 101 хувиар ханган биелүүлж, II ээлжийн цэрэг татлагаар ХЦ-т-90 хүнийг тэнцүүлэн хувиарлаж хяналтын тоог 100 хувь биелүүллээ.

ЗГ-ын 2009 оны 56 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 04 дүгээр тогтоолын дагуу 60 иргэнийг дүйцүүлэх албанд авч, 2009 оны 06 дугаар сарын 02-оос 14 хоногийн хугацаатай цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулсан. 2009 онд Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж байгаа иргэдийн мэдээг БХЯ-нд хугацаанд нь хүргүүлж байна. Дүйцүүлэх албыг биеэр хааж байгаа иргэдийг сумуудын ЗДТГ-т хуваарилж харилцан хүлээх үүргийн талаар гэрээ байгуулах ажлыг ЗГ-ын 49 дүгээр тогтоолын дагуу зохион байгууллаа.

Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдийн нэрсийг дахин тодотгож сумдад хүргүүлсэн бөгөөд 2009 оны жилийн эцсийн байдлаар байдлаар 7.137.526 төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлээд байна.

Цэргийн алба хаах насны залуучуудын бие бялдрыг чийрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр аймгийн ЭМГ, нэгдсэн эмнэлэг, сумдын эмч нартай хамтран ажиллаж байна. 2008 онд цэргийн албанд татагдсан иргэдийн 60 хувь нь эрүүл мэндээр тэнцээгүй бол 2009 онд нийт татагдсан иргэдийн 50.5 хувийг эрүүл мэндээр тэнцээгүй иргэд эзэлж байна. Энэ нь урд оныхоос буурсан үзүүлэлт гарлаа. 2008 онд цэргийн албанд дээд боловсролтой 3 иргэн татагдан алба хаасан бол 2009 оны цэрэг татлагаар дээд боловсролтой 16 иргэн алба хааж байна.

Дайчилгааны бэлэн байдал, шуурхай байдлыг хангах, зарлан мэдээллийг сум, багт тогтоосон хугацаанд хүргэх үүднээс аймгийн холбогдох байгууллагуудад тусгайлсан зааварчилгааг улирал бүрийн сүүлчийн сарын Баасан гаригт өгч, зарим сумдыг дадлагын дохиогоор ажиллуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан ажиллаж байна. Сумдын засаг дарга, ИТХ-ын дарга, ЗДТГ-ын дарга болон бусад холбогдох дарга нарт 2 удаа заавар чиглэл өглөө. Энэ онд 4 сум, аймгийн төвийн 32 байгууллагад үзлэг шалгалт хийж дайчилгааны даалгавартай болгох талаар чиглэл өглөө.

### **Гамшгаас хамгаалах талаар**

Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай хууль, ОБЕГ-ын даргын тушаал, шийдвэр, ОБЕГ-ын 2009 онд дэвшүүлсэн зорилт, Засгийн газар, Улсын Онцгой комиссын тогтоол, албан даалгаврууд, ОБЕГ, аймгийн Засаг даргын төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг сайжруулах тухай тушаал, албан даалгавар, захирамж, өгсөн үүрэг, чиглэлийг удирдлага болгон аймгийн нутаг дэвсгэрийн

хэмжээнд тохиолдож болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, бий болсон цагийн байдлыг бодитой үнэлж, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах, удирдлагаас оновчтой шийдвэр гаргахад үнэн зөв мэдээллээр хангах, аймгийн удирдлага болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, ОБЕГ-ын шуурхай удирдлага зохицуулалтын мэргэжилтэн, оператив жижүүрт мэдээ мэдээлэл, хүн, хүч хэрэгслийн хоногийн мэдээг цаг хугацаанд үнэн зөв өгч, цаг үеийн нөхцөл байдлыг тухай бүр мэдээлж өгсөн үүргийн дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллаа.

2009 онд 23 удаагийн гал түймрийн дуудлага хүлээн авч, үүнээс 13 удаагийн гал түймэрт байлдааны тархалт хийж, гал түймрийн улмаас 21061400 төгрөгийн хохирол учирч, 186459497 төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалсан байна.

Гамшиг ослын нийт 182 удаагийн мэдээ, мэдээлэл ирсэнээс автомашины гал түймэр 2, объектын гал 1, гэрийн гал 1, өвөлжөө бууцны гал 2, мал нохойд ноцуулсан 1, шуурганы хохирол 1, нууранд машин суусан 1, цасны хохирол 1, мал, амьтны галзуу өвчин гарсан тухай дуудлага 1, шуурганы мэдээ 3, тээврийн хэрэгслээр зорчигчид цасанд боогдсон тухай 10, цахилгаан эрчим хүчний гэмтэл 1, халаалтын шугам дахь усны алдагдалын мэдээлэл 9, томуу, томуу төст өвчний мэдээлэл 32, хүүхэд алга болсон тухай 20, малчид малтайгаа уруудаж олдохгүй байгаа тухай 36, цасан болон хүчтэй шороон шуурганы талаарх хохирлын мэдээ 19, малын хорогдлын мэдээ 8, хүн сураггүй алга болсон тухай 12, тээврийн хэрэгслээр зорчигчид их цасанд боогдсон тухай мэдээ 8, шуурганд гэр унасан тухай 20, барилгын дээврийн төмөр хуурсан тухай 8, айлын хашаа унасан тухай 10, нууранд хүүхэд живсэн тухай 1, Цээл сумын нутаг дэвсгэрт хүчтэй аадар бороо орсны улмаас үүссэн үерт урссан хүн, мал, эд материалын тухай мэдээлэл давхардсан тоогоор 6 удаа тус тус хүлээн авч, холбогдох арга хэмжээ, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллан үерт осолдон амь насаа алдсан 18 иргэний цогцсыг бүрэн олж ах дүү, төрөл төрөгсдөд нь хүлээлгэн өгсөн байна.

Цээл сумын нутаг дэвсгэрт үүссэн гамшигийн хор хөнөөлийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулж, аймгаас болон Цээл, Төгрөг сумдаас нийт 300 гаруй хүн, 30-аад автомашин дайчлан голын ай савыг цэвэрлэх, малын сэг зэмийг устгах, ариутгах, халдваргүйжүүлэх ажлыг 3 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Онцгой байдлын ерөнхий газар, Цаг уурын хүрээлэнгээс ирүүлсэн сэрэмжлүүлэг мэдээний дагуу бүх сумдын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг үүрэн телефоны утсаар болон багийн холбоогоор шуурхай хүргэж ажилласан болно.

Томуугийн цар тахлын А хүрээний (H1N1) вирусын халдварын тархалттай холбогдуулан Засгийн газрын тогтоолоор Монгол Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар өгөгдсөн үүргийн дагуу аймгийн Онцгой комисс 2 удаа, томуугийн А хүрээний (H1N1) вирусын халдвараас сэргийлэх шуурхай бүлэг 5 удаа хуралдаж, тус аймгийг дайран өнгөрдөг төв замуудад байнгын пост ажиллуулан хяналт тавьж, тээврийн хэрэгслээр орж, гарч байгаа зорчигчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан хяналт шалгалтыг эрчимжүүлж ажилласан байна.

Мөн аймгийн Засаг даргын Тамгын газарт аймгийн Онцгой Комиссын гишүүдийг өдөрт 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр хариуцлагатай жижүүрээр томилон, үүрэг гүйцэтгэх цагийн хуваарийг батлуулан, Гамшгаас хамгаалах төв штаб байгуулан ажиллуулж, мэдээ мэдээллийг төвлөрүүлэн холбогдох арга хэмжээ, зохион байгуулалтаар хангаж ажилласан байна.

Жаргалан, Дэлгэр, Тайшир сум, Гуулин тосгонд мэргэжлийн байгууллагуудтай хамтран томуугийн А хүрээний (H1N1) вирусын халдвараас урьдчилан сэргийлэх тандалтын арга хэмжээг

зохион байгуулсан бөгөөд энэ хугацаанд томуугийн А хүрээний (H1N1) вирус халдвараар аймгийн хэмжээнд 4 хүн өвчилж, эмнэлэгт эмчлэгдсэн байна.

Аймгийн Засаг дарга Монгол улсын Шадар сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээ, төлөвлөгөөний дагуу тус аймгийн төвд Гамшгаас хамгаалах Иж бүрэн сургуулийг 10 дугаар сарын 27, 28-нд зохион байгуулахаар төлөвлөн гамшгаас хамгаалах Иж бүрэн сургууль явуулах тухай Засаг даргын 2009 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 255 тоот захирамж гаргуулан албад, мэргэжлийн ангиудын бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлыг хангуулах тусгай төлөвлөгөө, ажил эрчимжүүлэх төлөвлөгөөг тус тус батлуулан бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.

Энэ удаагийн сургуулийг баталсан удирдамжийн дагуу “Гамшгийн хор уршгийг арилгах үеийн орон нутгийн төрийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, Онцгой байдлын хэлтэс, гамшгаас хамгаалах албад, аж ахуйн нэгж, байгууллагын харилцан ажиллагаа” сэдвээр зохион байгуулсан бөгөөд нийт 483 хүн, 53 машин техник хамрагдлаа. Сургууль удирдагчын зүгээс аймгийн гамшгаас хамгаалах Иж бүрэн сургуульд оролцсон гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн оролцоог “ДҮҮРЭН ХАНГАЛТТАЙ”, Иж бүрэн сургуулийг “ХАНГАЛТТАЙ” гэж дүгнэлээ.

### **Хууль тогтоомжийн биелэлтийн тухай:**

Хууль тогтоомжийн биелэлтэнд тавих хяналтын механизмыг өргөжүүлж, хууль хэрэгжүүлэх ажлыг төрийн байгууллагын бүх шатанд жигд хангах зорилгоор сумын Засаг дарга нарын нарын нэгдсэн семинарын үеэр тодорхой хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах, хяналтыг сайжруулах, илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулахад сумын Засаг даргаас хуульд заасан эрхээ бүрэн хэрэгжүүлж ажиллахад анхаарах асуудал, хуулийн хэрэгжилтийг шалгах ажлыг тогтмолжуулах чиглэлээр семинар өгч, заавар зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг мэргэжлийн байгууллагууд, сумын ЗДТГ-тай хамтран хуулийн хэрэгжилтийг шалгаж илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулахад онцгой анхааран ажиллаж байна. Тухайлбал архи согтууруулах ундаа худалдах, түүгэр үйлчлэх цагийн тоог орон нутгийн хүн амын тоонд нийцүүлэн шинэчлэн тогтоохтой холбогдуулж аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай, Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийг Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн хэлтэс, Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн хамтарсан 3 удаагийн шалгалтаар 72 зөрчил илэрч зөрчлийг газар дээр нь арилгуулах арга хэмжээ авлаа.

Аймгийн мэргэжлийн хяналтын газар, байгаль орчны алба, сумуудын ЗДТГ-тай хамтран Шарга, Халиун, Тонхил, Чандмана, Есөнбулаг сумдад Ашигт малтмалын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж хууль бусаар гар аргаар алт олборлогч давхардсан тоогоор 60000 орчим иргэдийг тараах, байгаль орчинд учруулсан хохиролыг нөхөн төлүүлэх, байгаль орчныг сэргээлгэх, байгаль орчныг сүйтгэхэд ашигласан багаж хэрэгсэлийг хураах зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллалаа.

Мөн хууль бусаар ховор болон нэн ховор ан амьтдыг агнах явдалтай тэмцэх мэргэжлийн хяналтын газартай хамтран төлөвлөгөөний дагуу ажиллаж энэ асуудлаар аймгийн Засаг даргын 2 захирамж гарч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Аймгийн ГХУСАЗЗ-ийн даргын баталсан удирдамжийн дагуу “Ажлын хариуцлага-сонор сэрэмж” нэгдсэн арга хэмжээний хүрээнд 12 байгууллага, аж ахуйн нэгжид Гэрээт харуул, хамгаалалтын тухай

хуулийн хэрэгжилт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, ажил, харуул, манаа, галын аюулгүй байдлыг шалгаж, нийт 191 хүнд хууль сурталчилан, холбогдох хууль тогтоомжуудаар тестийн шалгалт авч, 50 гаруй зөвлөмжийг тарааж нэр бүхий 4 албан тушаалтанд хариуцлага тооцон ажиллалаа.

Мөн Төрийн албаны байранд баяр ёслол, тэмдэглэлт өдрүүдийг зохион байгуулалттай тэмдэглэж буй байдалд үзлэг шалгалтын ажлыг Есөнбулаг сумын төвийн 25 албан газарт аймгийн ИТХ-ын дэргэдэх Төр эрх зүйн хороо, Цагдаагийн хэлтэстэй хамтран 2009 оны 3 сарын 6-9-ны хооронд зохион байгууллаа.

Шалгалтанд хамрагдсан байгууллагуудаас Олон улсын эмэгтэйчүүдийн баярын хүлээн авалтыг зохион байгуулалттайгаар байгууллага дээрээ тэмдэглэж байсан 5 газрын дарга, захирал нарт аймгийн Засаг даргын захирамжаар сахилгын арга хэмжээ авч, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд аливаа баяр ёслол, тэмдэглэлт өдрүүдийг архи, согтууруулах ундаагүйгээр тэмдэглэн өнгөрүүлж байх талаар аймгийн Засаг даргын захирамжаар үүрэг чиглэлийг өгч хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2009 оны эхний хагас жилийн гэмт хэргийн танилцуулгыг хэлэлцүүлж байгууллага, аж ахуйн нэгжүүдэд 15 заалт бүхий үүрэг чиглэлийг гарган холбогдох сум, байгууллагуудад хүргүүлж биелэлтийг нь тооцон ажиллалаа.

Мөн орон даяар өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан Есөнбулаг сумын ЗДТГ, Мэргэжлийн хяналтын газар, Хүүхдийн төлөө хэлтэстэй хамтран тоглоомын газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд 2 РС тоглоомын газар ажиллаж байсныг илрүүлж зөрчлийг арилгуулан үйл ажиллагааг нь хаалгах арга хэмжээ авч ажиллалаа.

### ***Иргэний бүртгэл мэдээллийн ажлын талаар***

Иргэний гэр бүлийн байдлын мэдээ тайланг цаг хугацаанд нь нэгтгэн гаргаж бүртгэлийн ХААТР маягтуудыг тухай бүрд нь хянаж хагас жилээс хойшхи ХААТР маягтуудыг бүртгэлийн нэгдсэн сүлжээнд шивэн, ХААТР-11-18 1594, ХААТР-22-24 1907 мэдээллийн санд баталгаажуулан оруулж эхэллээ. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн 2009 онд хэрэглэгдэх 15 төрлийн ХААТР маягт гэрчилгээг төвөөс татан авч сумдад захиалгын дагуу хуваарилан олгож зарцуулалтанд нь хяналт тавин ажиллалаа.

2009 онд төрсний гэрчилгээ олгосон хүүхэд 1475, гэрлэлт бүртгүүлсэн 699 өрх, гэрлэлт цуцлалт-10, үрчлэлт-44, эцэг тогтоолт-35, овог эцэг эхийн нэр, нэр өөрчлөлт-182, нас баралт-364 хугацаа хэтэрсэн төрөлт 10, тус тус бүртгэгдсэн байна. Хүн амын шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэж бусад аймаг хотруу бүрмөсөн шилжихийг хүссэн 937 иргэний өргөдөл материал хүлээн авч 232 өрхийн 1814 иргэний шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэж шийдвэрлэсэн буюу өөр аймаг хотоос шилжин ирсэн 32 өрхийн 410 иргэнийг бүртгэж хаягийн бүртгэлд бүрэн хамруулсан байна.

Тайлангийн хугацаанд гадаадад зорчихыг хүссэн иргэдийн гадаад паспорт авах өргөдөл хүсэлт хүлээн авч 171 иргэнд гадаад паспорт шинээр олгож, 306 иргэний гадаад паспортын хугацааг сунгаж, эцэг эхийн хамт гадаадад зорчихыг хүссэн 9 хүүхэд хүүхдийн хавсралт олгож хил 1 удаа нэвтэр үнэмлэх 47, олон удаа гарах үнэмлэх 3 тус тус олгож санхүүгийн тооцоог тухай бүрд нь хийлээ.

МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд аймгийн хэмжээнд сумдын халамж үйлчилгээ болон бусад төрийн үйлчилгээний газруудтай хамтран орон нутгийн шилжүүлэггүй болон бичиг баримтгүй нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэдийн судалгааг гаргаж

хүн амын өрхийн болон хаягийн шинэчлэсэн бүртгэлд бүрэн хамруулах, бичиг баримтын зөрчлийг арилгах ажлыг аймгийн Засаг даргын 2009 оны 70 тоот захирамжийн дагуу ажлын хэсэг төлөвлөгөө гарган 1 сарын хугацаатай бичиг баримтын үзлэгийг 123 ажлын хэсэгт 322 хүн ажиллаж зохион байгуулж үзлэгт аймгийн хэмжээнд нийт хамрагдвал зохих өрх хүн амын 96% хамрагдаж үзлэгээр илэрсэн 450 гаруй иргэний хаягийн бүртгэлийн өөрчлөлт, иргэний үнэмлэхний хүчинтэй хугацаа дууссан 258 иргэний үнэмлэхийг сунгаж, бичиг баримтаа хаяж үргэдүүлсэн 120 иргэнийг торгууль шийтгэлгүйгээр дахин үнэмлэхжүүллээ. Зөрчлийг богино хугацаанд арилгаж сонсогчийн нэрсийн жагсаалтыг багийн дарга нартай тулган сонгуулийн хороонд хүлээлгэн өгсөн.

Нээлттэй хаалганы өдрийг сар бүрийн 2 дахь долоо хоногийн бямба гаригуудад аймгийн төвд болон нийт сумдад тогтмол зохион байгуулж иргэний бичиг баримтын хууль эрх зүйн ач холбогдлыг таниулах, иргэдээс иргэний үүргээ биелүүлэхийг уриалсан ухуулга сурталчилгааны ажлыг явуулж иргэдэд 7 төрлийн гарын авлага материалыг тараан өгч нээлттэй хаалганы өдрүүдэд нийт хаягийн зөрчилтэй 450 иргэний хаягийн зөрчлийг арилгаж бичиг баримтаа хаяж үрэгдүүлсэн -791 иргэнийг үнэмлэхжүүлж, насны сунгалт-85 хүний иргэний үнэмлэхний материалыг хүлээн авч хэвлэсэн.

Тайлангийн хугацаанд шинээр иргэний үнэмлэх авах иргэдийн судалгааг аймгийн өрөнхий боловсролын сургуулиуд болон багийн дарга нартай хамтран судалгаа гаргаж бичиг баримтын зөрчилгүй 1494 иргэнд шинээр, хугацааны сунгалт дууссан 1932 иргэн, иргэний үнэмлэхээ хаяж үрэгдүүлсэн 791 иргэнд дахин иргэний үнэмлэх олгож нийт 4240 иргэнийг үнэмлэхжүүлсэн байна.

#### ***Нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар***

Аймгийн ГХУСАЗЗ-ийн бүрэлдэхүүнийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 1-р сарын 22-ны өдрийн 08 тоот тогтоолоор шинэчлэн баталж, зөвлөлийн хурлыг 3 удаа зохион байгуулж хуралдаанаар 2008 онд зохион байгуулсан ажлын тайлан, 2009 онд зохиох ажлын төлөвлөгөө, гишүүдийн ажил үүргийн хуваарийг шинэчлэн баталж, тухай улиралд хийсэн ажлынхаа тайлан, мэдээг сонсож, дараа улиралын төлөвлөгөөг хэлэлцэн баталж ажиллалаа.

Аймгийн Засаг даргаас хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж Цагдаагийн хэлтэст хөдөлгөөнт эргүүлийн 4 авто машин өгч аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд жигд татан оролцуулах зорилгоор баталсан хуваарийн дагуу 9 байгууллага, аж ахуйн нэгж, 4 багийн Засаг дарга нарыг аймгийн Цагдаагийн хэлтсийн хөдөлгөөнт эргүүлтэй хамтран нийтийн эргүүлд томилон ажиллуулсан нь гудамж талбайд үйлдэгддэг танхайн хэрэг 30 хувиар, бусдын эрх чөлөөнд халдах хэргийн гаралт 46 хувиар бууруулахад зохих үр дүнгээ өгсөн ажил боллоо.

Аймгийн ГХУСАЗЗ-тэй хамтран нийт 18 суманд “Гэмт хэрэг зөрчилгүй сум болох” сарын аяныг өрнүүлж сумдын салбар зөвлөлөөс зохион байгуулсан ажлын тайлан, хурлын тэмдэглэлийг хүлээн авч үр дүнг нь тооцон ажиллав.

Тус аймгийн Бигэр сумын нутагт хууль бусаар гар аргаар алт олборлогчдыг тараасантай холбогдуулж Говь-Алтай аймгаас Улаанбаатар хотын чиглэлд явж байгаа зорчигч иргэдийн эрх чөлөөнд халдах, автомашины цонхыг хагалах зэргээр танхайрах явдал удаа дараалан гарч, уг асуудлын улмаас иргэд эд хөрөнгө, эрүүл мэнд, амь насаараа хохирох нөхцөл үүссэн тул зорчигчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор хуулийн байгууллагуудтай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, эргүүл шалгалтын ажлыг тогтмол ажиллуулах хүсэлтийг Баянхонгор,

Өвөрхангай аймгийн ГХУСАЗ-х зөвлөлд албан ёсоор тавьсаны дагуу Баянхонгор аймгийн Хөх эргийн гарамд хөдөлгөөнт эргүүл зохион байгуулж зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч ажиллалаа.

Аймгийн хэмжээнд 2009 оны жилийн эцсийн мэдээгээр гэмт хэргийн улмаас төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмч хөрөнгөд 369.3 сая төгрөгийн хохирол учирч, 123 гэмт хэрэг үйлдэгдсэнийг мөн оны өмнөх үетэй харьцуулбал гэмт хэрэг 54 буюу 30.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 11 сард Алтай хотын мал, махан бүтээгдэхүүн худалдаалдаг аж ахуйн нэгж, цэг, салбар, иргэдийн үйл аиллагаанд аймгийн ГХУСАЗЗ, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн хэлтэстэй хамтран хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа. Уг шалгалтаар тусгайлан эрх олгон зөвшөөрсөн цэгээс өөр газарт мал нядалж байсан 3 цэгийг илрүүлэн холбогдох хуулийн хүрээнд арга хэмжээ авч, зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулах арга хэмжээ авч ажиллалаа.

Малын хулгайн гэмт хэрэг өмнөх онтой харьцуулахад өсч, буураагүй байна. Мах бэлтгэх ажилд малын гарал үүслийн гэрчилгээг бүрэн хийлгэж, энэ төрлийн хэрэг зөрчил гаргахгүй байх чиглэлээр холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, малчидтай хамтран ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2009 оны 95 дугаар захирамжаар архи согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх цэгийн тоог 2 дахин цөөрүүлж, тусгай зөвшөөрөл олгох ажлыг сонгон шалгаруулалтын журмаар зохион байгуулж байна.

Согтууруулах ундааны хэрэглээ нэмэгдэж, хэрэглэгчид нь улам бүр залуужиж гэр бүл, байгууллага, хамт олон, хүмүүсийн хоорондын зүй бус харилцаа, хүчирхийлэл, гэмт хэрэг эрх зүйн зөрчлийн үндсэн нөхцөл болсон архидан согтуурах явдалтай хийх тэмцлийг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2009 оны 134 дүгээр захирамжийг гаргуулж захирамжийн дагуу Хууль зүйн хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газрын дарга нарын хамтран баталсан удирдамжтай “Архидан согтуурахын эсрэг тэмцье” 1 сарын аяныг аймгийн хэмжээнд зохион байгууллаа.

Аяны хүрээнд архи, согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 3 үйлдвэр, 52 цэг, 3 ресторан, 7 баар, Шинэ Алтай захын 256 павилон, чингэлэгт үзлэг шалгалт хийж, БНХАУ-д үйлдвэрлэсэн FENJINTING шошготой 0.5 литрээр савлагдсан 576 шил архи, 650 литр пийжүүг хураан авч устгалын комиссоор устгуулан, тусгай зөвшөөрөлгүйгээр архи, согтууруулах ундаа худалдаж болзошгүй 6 цэг, 12 айлаар үзлэг шалгалт хийж 290 литр архи, 40 литр пивийг хураан авч Мэргэжлийн байгууллагуудад шилжүүлэн холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох явдалтай тэмцэх зорилгоор “Согтуу-1, 2, 3, 4, 5” тусгай арга хэмжээг зохион байгуулж, аймгийн төвөөр дайран өнгөрдөг улсын чанартай төв замд байнгын ажиллагаатай постыг ажиллуулан 4740 тээврийн хэрэгслийг шалгаж ачаа тээшинд нь үзлэг хийн 1485 зөрчил илрүүлэн 181 хүнд 920.0 мянган төгрөгний торгуулийн арга хэмжээ авч шийдвэрлэсэн байна.

Мөн аймгийн төвөөс гарах орох замуудад өдөр бүр хөдөлгөөнт эргүүлүүдийг ажиллуулан согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 41 жолоочийн эрхийг 6 сараас 2 жилийн хугацаагаар хасч, 17 хүнийг шүүхийн шийдвэрээр баривчлуулан, 89 тээврийн хэрэгслийг түр саатуулан ажиллав.

Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хүрээнд авлигын хор уршиг, хуулийн зорилт, хуульд хамрагдах албан тушаалтан, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах, түүнийг олон нийтэд ил тод байлгах зэрэг сэдвүүдээр бэлтгэж мэдээлэл сурталчилгааг хийж ажиллав.

Авлигын тухай хуульд заасан төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг шинэчлэх хуулийн хугацаанд сумдын Засаг даргын тамгын газрын дарга нар болон агентлагын дарга нарт Авлигын тухай хуулийг сурталчлан гарын авлага материалыг тараан өгч хуулийн хугацаанд Төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг шинэчлэн гаргуулж, авлигатай тэмцэх газар хүргүүлээ.

Тайлангийн дүн мэдээгээр аймгийн хэмжээнд

-Төрийн захиргааны албан хаагч 243

-Төрийн тусгай албан хаагч 3

- Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан 12

Бусад төсөвт байгууллагын захирал, эрхлэгч 75 нийт 333 албан тушаалтан хөрөнгө орлогын мэдүүлэгээ мэдүүлснийг хүлээн авч бүртгэж ажиллалаа.

2009 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд шинэчлэн гаргахтай холбогдуулж Сум , агентлагын дарга нарт хөрөнгө орлогын мэдүүлэг гаргахад гардаг алдаа зөрчлүүдийн талаар зөвлөмж материалыг бэлдэж, 150 сурталчилгааны материал хүргүүлж ажилласан.

#### **Гадаад харилцааг өргөжүүлэх тухай:**

2009 онд хамтын ажиллагаатай улс орнуудтай уламжлалт харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлж, олон улсын төслийн байгууллагатай хамтран, хөтөлбөр төслийг аймгийн боловсрол, эрүүл мэнд, соёл шинжлэх ухаан, техник, эдийн засаг, үйлдвэрлэл үйлчилгээ, худалдааг хөгжүүлэхэд чиглүүлэн ажиллаж ирлээ.

Швейцарийн холбооны улсын хамтын ажиллагааны газрын Монгол дахь суурин төлөөлөгч, Швейцарийн холбооны улсын өргөмжит консул Маркус Дубах тэргүүтэй төлөөлөгчид айлчилж, Швейцарийн холбооны улсын Юра мужтай 2008-2015 онд хамтран ажиллах хэлэлцээр хийж, сүүлийн 2 жилд хийх ажлын талаар хамтран тохиролцлоо.

Зүүн хойд Азийн бүс нутгийн засаг захиргаадын холбоотой байнгын харилцаатай ажиллаж, тэдний зохиосон олон улсын эдийн засгийн форум, хуралд Солонгос улсад аймгийн Эрүүл мэндийн газрын дарга 5 дугаар сард, БНХАУ-ын Шандунь мужийн Чэндо хотод болсон үзэсгэлэн яармагт аймгийн Засаг даргын орлогч 11-р сард оролцоод ирлээ.

БНХАУ-ын ШУӨЗО-ны Хами аймгийн Засгийн ордны дарга Гулисыяи Абүдүхадерийн урилгаар аймгийн Засаг дарга тэргүүтэй төлөөлөгчид 2009 оны 12 сарын 24-28-ны өдрүүдэд Хами хотод ажлын айлчлал хийж, 2 талын хамтын ажиллагааг өргөжүүлэх хөгжүүлэх хэлэлцээрт гарын үсэг зурлаа. Энэхүү хэлэлцээрт 2 аймгийн нийгэм эдийн засаг, хамтын ажиллагааг эрчимжүүлж, өргөн хүрээтэй хамтран ажиллахаар боллоо.

ӨМӨЗО-ны Хөх хотод аймгийн Засаг дарга тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын Засгийн Ордоны дэд нарийн бичгийн дарга, Гадаад хэрэг эрхлэх газрын дарга Жиан Вэйгийн урилгаар 2009 оны 12 сарын 5-9-ний өдрүүдэд ажлын айлчлал хийж, Монгол улсын Говь-Алтай аймаг, БНХАУ-ын ӨМӨЗО-ны хооронд найрсаг харилцаа тогтоох тухай 2008 оны 12 сард үзэглэсэн

хэлэлцээрт гарын үсэг зурлаа. Уг хэлэлцээрт 2 тал эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан техник, соёл боловсрол, биеийн тамир спорт, эрүүл мэнд болон хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллахаар тохиролцлоо.

Ховд аймагт зохион байгуулагдсан баруун бүсийн зөвлөлдөх уулзалтын үеэр олон улсын хөрөнгө оруулалтын чуулга уулзалтанд оролцож, "Олон улсын түншлэл, хамтын ажиллагаа" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд аймгийн Засаг дарга Говь-Алтай аймгийн барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага сэдвээр илтгэл тавьж, ХХААХҮЯ-ны өдрүүдийн арга хэмжээ болон Баруун бүсийн үзэсгэлэн худалдаанд аймгийн удирдлагууд болон бизнес эрхлэгчдийн төлөөлөгчид оролцлоо.

Бургастайн боомтыг байнгын ажиллагаатай болгох талаар Гадаад харилцааны яам болон холбогдох байгууллага, УИХ-ын гишүүдэд 2 удаа хүсэлт тавиад байна.

Мөн Гадаад харилцааны яаман дээр болсон Монгол улсын гадаад харилцааг эдийн засагжуулахад тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцсэн үндэсний зөвлөгөөнд аймгийн Засаг дарга, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн нар оролцож, Монгол улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Бургастай-Лаомяо боомтыг байнгын ажиллагаатай болгох асуудлаар Хятадын талтай тохиролцох, Бургастайн боомтын дэд бүтцийг бий болгох зэрэг асуудлыг тусгаж батлуулсан байна.

Бургастайн боомтоор таван удаа хилийн худалдаа хийж, төмрийн хүдрийн баяжмал, барилгын тоног төхөөрөмж зэрэг 5.2 сая ам.долларын бүтээгдэхүүн гаргаж, цемент, нүүрс, тоосго, болон барилгын бусад материал, тоног төхөөрөмж зэрэг 1.5 сая ам.долларын бараа материал оруулж ирэв.

БНХАУ-ын ШУӨЗО-ны Зам тээврийн харилцааны яамны төлөөлөгчдийн ээлжит уулзалт Урумчи хотод 2009 оны 10 сард болж, Аймгийн Тээвэр, автозамын газрын дарга оролцож, Бургастай, Ярант боомтуудаар гарч байгаа Монголын тээвэрчдэд учирч байгаа бэрхшээл түүнийг арилгах арга замын тухай санал солилцож, 2 тал хамтран шийдвэрлэхээр тохиролцсон байна.

Гадаадын хөрөнгө оруулагчдын үйл ажиллагааг дэмжсэн бодлого баримталж, үүний үр дүнд цөөнгүй олон улсын байгууллага болон гадаадын төсөл хөтөлбөр, зээл тусламжинд хамрагдаад байна. Үйлдвэрлэл, газар тариалан, хөдөө аж ахуй, ядуу дунд орлоготой иргэдэд зориулсан зээл, оюутнуудын сургалтын тэтгэлэг, сургалт зөвлөгөө, үзэсгэлэн худалдаа зэрэг салбарт төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна.

Аймгийн боловсролын салбарт 2009 онд олон улсын "Каталик" сан, Дэлхийн банкны санхүүжилтээр "Үр дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл" хөтөлбөрийн хүрээнд Дарив сумын сургуулийн дотуур байрны их засварт 140,2 мянган ам.доллар, Алтай, Баян-Уул, Жаргалан, Төгрөг, Хөхморьт сумдын сургуульд тус бүр 10 ширхэг, нийт 50 ширхэг компьютерийн 19.0 мянган ам.доллар, 1 дүгээр ангийн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтанд 75 багш хамрагдаж 13.1 мянган ам.доллар, бага ангийн багш нарын мэдээллийн харилцаа технологийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд 85 багш хамрагдаж 9.2 мянган ам.доллар, дунд сургуулиудад 3 төрлийн 408 ширхэг ном, гарын авлага материалд 0.8 мянган ам.долларын хөрөнгө оруулалтууд хийгдлээ.

НҮБ-ын Хүн амын сангийн НҮЭМ-ийн хөтөлбөрийн санхүүжилтээр 4,5 сая төгрөгийн сургалт, сурталчилгаа хийж, Алтай, Бигэр, Есөнбулаг сумын 1 дүгээр сургуулиудад 8,2 сая төгрөгийн "Эрүүл мэндийн өргөө"-г тохижуулсан байна.

АНУ-ын Азийн сангийн “Гол усанд чанарын хяналт шинжилгээ” төслөөс Тайшир, Жаргалан, Гуулингийн сургуулиудад 3,6 сая төгрөгийн “Биологийн бичил лаборатори”, экологийн чиглэлээр 24 сургагч багш бэлтгэхэд 1,6 сая төгрөг зарцуулсан байна.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн “Тогтвортой хөгжил-бөхөн хамгаалал” төслөөс Шарга, Төгрөг, Дарив, Хөхморьт, Баян-Уул сумдад 4,6 сая төгрөгийн сургалт, гарын авлага материал тараахад зарцуулсан байна.

Аймгийн эрүүл мэндийн салбарт 2009 онд Норвегийн тусламжийн байгууллагын “Эрүүл мэндийн анхан шатны тусламжийн чадавхийг бэхжүүлэх” төслөөр сум, өрхийн эмнэлгүүдийн үйл ажиллагааны чадавхийг сайжруулах, эмнэлгийн яаралтай тусламжийн стандартыг хэрэгжүүлж, үр дүнг тооцон, 10 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, 5 сая төгрөгөөр эрүүл мэндийн сургалт мэдээллийн төвийг тохижуулж, Норвегийн тусламжийн байгууллага, ДЭМБ, НҮБХАС-ийн тусламжтай 30 төрлийн сургалтанд 1762 эмч, мэргэжилтэн хамрагдаж, 1,5 сая төгрөгийн багц цаг тараалаа. НҮБХАС-ын НҮЭМ-ийн IY хөтөлбөрийн хүрээнд Бигэр, Алтай сумд 71 сая төгрөгийн 55 нэр төрлийн тоног төхөөрөмж суурилууллаа.

Азийн хөгжлийн банкны ЭСХХ-3 төслөөр Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 300 сая төгрөгийн барилгын их засвар хийгдэж, Алтай, Бигэр сумд ундны усны 2 худаг гаргалаа.

ДЭМБ-ын санхүүжилтээр 11,6 сая төгрөгөөр Тайшир, Дэлгэр сумын хүн эмнэлгийн усан хангамж, цэвэр бохирын шугамыг шинэчиллээ.

Мөн Дэлхийн зөн олон улсын байгууллага “Андууд” зусланд сувилал ажиллуулж, нийт 220 эх, хүүхдийг хамруулж, 4.4 сая төгрөг, томуугийн А хүрээний N1H1 вирус эсрэг эрүүл мэндийн сургалт суртчилгаа, гарын авлага материал тараахад 20.7 мянган ам доллар, ард иргэдэд эрүүл ахуй, ариун цэврийн хэрэгсэл, нэмэлт хүнсний бүтээгдэхүүн, түлш олгоход 8.1 мянган ам доллар зарцуулсан байна.

Засгийн газрын хэрэг эрхлэх газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Говь-Алтай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хооронд харилцан ойлголцлын санаамж бичиг 2008 оны 1 дүгээр сард байгуулснаар орон нутгийн засаглалыг дэмжих төсөл хөтөлбөр хэрэгжиж, төвлөрлийг сааруулах бодлогын туршилтын хүрээнд орон нутгийн санхүүгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, хөгжлийн асуудлаа бие даан төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавихад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулж, орон нутагт 49 төсөлд 193 сая. төгрөгийн санхүүжилт хийсэн байна.

Энэ онд тус аймгийн 26 төрийн албан хаагч БНХАУ, Япон, Солонгос, Египет, Тайвань, Гонконг зэрэг гадаадын орнуудад албан айлчлал, хурал зөвлөгөөн, мэргэжил дээшлүүлэх сургалт зэрэгт хамрагдсан байна. Аймагт ОХУ, БНХАУ, Солонгос, Япон, АНУ-ын 40 гаруй иргэн тус тус 30 хоног хүртэлх хугацаагаар зорчсон байна. Тус аймагт АНУ-ын 2 иргэн 2 жилийн хугацаатай оршин сууж, Анагаах ухааны коллеж, ерөнхий боловсролын сургуульд багшилж байна.

## **5.2. Хэрэглэгчийн үнэлгээ**

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт болон агентлагын ажлын үр дүнгийн талаар 6 удаа нээлттэй хаалганы өдөрлөгийг аймгийн төвд зохион байгуулж иргэдээс санал авах хайрцаг, нээлттэй утас, mail хаяг, уулзалтын үед нийт 1641 санал хүсэлтийг хүлээн авсанаас 1183 санал хүсэлтийг нь газар дээр нь шийдвэрлэв. Энэ үеэр иргэдээс аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар сэтгэл ханамжийн судалгаа авлаа. Судалгаанд оролцсон нийт иргэдийн 55.5 хувь нь Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангалттай,

33.9% нь дунд зэрэг, агентлаг албадын ажлыг 24.1 хувь нь хангалттай, 42.7 хувь нь дунд зэрэг гэж дүгнэжээ.

Аймгийн хэмжээнд нийт 64 ТББ бүртгэлтэй байдаг ба хүн ам, нийгмийн чиглэлийн 26, ХАА-н чиглэлийн 8, төсөл хэрэгжүүлэгч 4, бизнесийн чиглэлийн 2, боловсролын чиглэлийн 6, спортын чиглэлийн 5, шашны 1, бусад чиглэлээр 12 ТББ байдаг. Үүнээс тогтмол, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 35 орчим ТББ байдаг.

Жил бүр аймгийн удирдлагууд ТББ-ын тэргүүнүүдтэй уулзаж, санал бодлоо солилцож, өмнөх жилийн ажлаа дүгнэж, хамтран ажиллах чиглэлээ тогтоон, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тодорхой асуудлуудыг тусган хэрэгжүүлж ирсэн билээ.

2009 оны үндсэн чиглэлд “ТББ-уудын үйл ажиллагааг идэвхижүүлэх, хамтран ажиллах чиглэлээр” 4 заалт тусгагдсан ба хэрэгжилт нь 87.5 хувьтай байна.

Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ХЭАХ хуулийг сурталчилах, иргэдийн санал, хүсэлт, өргөдөл гомдлыг барагдуулах ажлын чиглэлээр аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээг 2009.03.28-ны өдөр байгуулан ажиллалаа. Гэрээнд тусгагдсан 3 багц, 17 дэд заалтын биелэлт нь 82.4%-тай байна.

Аймгийн УЗХ-той байгуулсан 2009 оны гэрээндээ гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 зорилт тусган хамтран ажиллаж биелэлт 80%-тай байна.

Ахмадын хороотой аймгийн ЗДТГ-ын дарга хамтран ажиллах 10 заалт бүхий гэрээ байгуулж ажиллалаа.

Засгийн газрын 2008 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 22-р тогтоолоор “Иргэний нийгмийн өдөр-1 дүгээр сарын 31”-ийг тэмдэглэн өнгөрүүлээ.

**Говь-Алтай амйгийн Засаг даргын Тамгын гарын 2009 оныүйл ажиллагаа 94.6 хувьтай байна.**